

**ВИРЖИНИЯ МУЖИЙН БОЛОВСРОЛЫН ЯАМ
ТУСГАЙ БОЛОВСРОЛ, СУРАГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБА**

Таны Гэр Бүлийн Тусгай Боловсролын Эрх

ВИРЖИНИЯГИЙН ЖУРМЫН ХАМГААЛАЛТ¹ МЭДЭГДЭЛ ТУСГАЙ БОЛОВСРОЛЫН ЖУРМЫН ХАМГААЛАЛТАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

2013 оны 9-р сард шинэчлэгдсэн

Энэхүү баримт бичиг нь Виржиниагийн Боловсролын Яамны (VDOE) 2012 оны 10-р сарын журмын хамгаалалт баримт бичигт орж буй өөрчлөлт юм. Эдгээр өөрчлөлтүүд нтэ дараах эрхзүйн шаардлагуудыг тусгасан байна:

- *Хөгжлийн Бэрхиээлтэй Иргэдийн Боловсролыг Дээшлүүлэх Тухай Хууль* 2004 (IDEA; P.L. 108-446; 20 USC § 1400 et seq.) 2004 оны 12 дугаар сарын 3-ны өдөр батлагдаж; 2005 оны 7-р сарын 1-ний өдөр хэрэгжиж эхэлсэн.
- IDEA-г хэрэгжүүлэх Холбооны дүрэм. 34 CFR 300-р хэсэг. 2006 оны 8 дугаар сарын 14-ний өдөр батлагдаж; 2006 оны 10-р сарын 13-ны өдөр хэрэгжиж эхэлсэн.
- Холбооны IDEA-ийн нэмэлт зохицуулалт; 34 CFR 300-р хэсэг; Улсын бүртгэл, 2009 оны 73 дугаар сарын No231. 2008 оны 12 дугаар сарын 01-ний өдөр батлагдаж; 2008 оны 12 сарын 31-ны өдөр хэрэгжиж эхэлсэн.
- Холбооны IDEA нэмэлт зохицуулалт: 34 CFR хэсэг 300; Улсын бүртгэл, 2008 оны 78 дугаар сарын 31-ний өдөр 2013 оны 02 дугаар сарын 14-ний өдөр гаргасан; үр дүнтэй 2013оны 3 дугаар сарын 18-ны өдөр хэрэгжиж эхэлсэн.
- *Виржиниа дахь хөгжлийн бэрхиээлтэй хүүхдийн тусгай боловсролын хөтөлбөрүүдийг зохицуулах журам* (Виржиниа мужийн Хуулиад). 8 VAC 20-81-10 et seq. 2009 оны 7-р сарын 7-нд батлагдаж, хэрэгжиж эхэлсэн.

Энэхүү баримт бичиг нь АНУ-ын Боловсролын Яамны¹ загвар журмын хамгаалалтын мэдэгдэлтэй (2009 оны 6-р сард засварласан) нийцэж байгаа бөгөөд энэхүү мэдэгдэлд заавал оруулах ёстой Виржиниагийн тодорхой шаардлагуудыг багтаасан болно.

Тусгай боловсролын тухай болон эдгээр журмын хамгаалалтын талаар нэмэлт мэдээллийг тусгай боловсролын орон нутгийн удирдлага буюу сургуулийн захирал, өөрийн орон нутгийн сургуулийн дүүргийн Эцэг эхийн Мэдээллийн Төв, Эцэг Эхийн Боловсролын Өмгөөллийн Сургалтын төв (PEATC) буюу VDOE-ийн Маргаан шийдвэрлэх, удирдах албаны 804-225-2013 утсаар холбогдож авах боломжтой. Энэ баримт бичгийг мөн дараах эх сурвалжаас үзэх боломжтой: <https://www.doe.virginia.gov/home/showpublisheddocument/922>

Үнэгүй утас: 800-422-2083

Үнэгүй TDD Утас:800-422-1098

¹ *Procedural Safeguards: Хөгжлийн Бэрхиээлтэй Иргэний Тухай хууль (IDEA)-ийн дагуу хөгжлийн бэрхиээлтэй сурагч нь төрөөс үзүүлэх үнэгүй ерөнхий боловсролын үйлчилгээнд хамрагдах, хөгжлийн бэрхиээлтэй сурагчийн боловсрол, тусгай хэрэгцээт боловсролын үйл явцын бүх шатанд эцэг эх бүрэн мэдээлэлтэй байж, үйл явцад бүрэн мэдээлэлтэй оролцох, шийдвэр гаргах эрхийг хамгаалсан эрхзүйн хамгаалалт. Цаашид “Журмын Хамгаалалт” гэж товчилж нэрлэх. Орчуулагч.*

АГУУЛГА

Ерөнхий мэдээлэл	3
Процедурын хамгаалалт гэж юу вэ	3
Тойм: Тусгай боловсролын зарим чухал нэр томъёо	3
Урьдчилан Бичгээр мэдэгдэх	4
Төрөлх хэл.....	5
Электрон шуудан	5
Аудио болон видео бичлэг	6
Эцэг эхийн зөвшөөрөл-Тодорхойлолт	6
Эцэг эхийн зөвшөөрөл.....	7
Бие даасан боловсролын үнэлгээ.....	11
Мэдээллийн нууцлал.....	13
Тодорхойлолтууд.....	13
Хувь хүнийг таних мэдээлэл.....	13
Эцэг эхчүүдэд өгөх мэдээлэл.....	13
Мэдээлэлд Нэвтрэх эрх	14
Бүртгэлд Нэвтэрсэн Харилцааг Бүртгэх.....	15
Нэгээс дээш хүүхдийн бүртгэл.....	15
Мэдээллийн төрөл, байршлын жагсаалт.....	15
Хураамж	15
Эцэг эхийн хүсэлтээр бүртгэлд өөрчлөлт оруулах тухай.....	15
Сонсгол Оролцох боломж	16
Сонсгол Явуулах Журам	16
Сонсголын үр дүн	16
Хувь хүний таних мэдээллийг ил тод мэдээлэх зөвшөөрөл.....	17
Хамгаалалт	17
Мэдээлэл устгах	18
Маргаан шийдвэрлэх Хувилбарууд.....	18
Зуучлал.....	18
Мужийн гомдол шийдвэрлэх журам	20
Процессын сонсгол болон мужийн гомдол гаргах журам хоорондын ялгаа.....	20
VDOE-ийн өргөдөл гомдлыг шийдвэрлэх журмыг авч ашиглах.....	20
VDOE Гомдол шийдвэрлэх журамд тавигдах үндсэн шаардлага.....	21
Гомдол гаргах.....	22

Эрхзүйн Процессынⁱⁱ Журам.....	23
Эрхзүйн Процессын Сонсголын ⁱⁱⁱ Хүсэлт Гаргах	23
Эрхзүйн процессын Хүсэлт	23
Жишиг Маягтууд	25
Эрхзүйн процессын Сонсгол хүлээж байх явцад хүүхдийг хөтөлбөрт хуваарилах	25
Шийдвэрлэх үйл явц	26
Хараат бус эрхзүйн процессын сонсгол	28
Сонсгол явуулах эрх.....	29
Сонсголын шийдвэр	30
Шийдвэр гаргах хугацаа, Хуралдааны тохиромжтой байдал ба Хяналт.....	31
Иргэний хэргийн нэхэмжлэл, нэхэмжлэл гаргах хугацаа	31
Хуульч, Эрхзүйн Зардал, Төлбөр.....	32
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сахилгын арга хэмжээ авах үед баримтлах журам	34
Сургуулийн ажилтнуудын эрх мэдэл.....	34
Сахилгын улмаас хасагдсанаар хөтөлбөрийн хуваарилалт өөрчлөгдөх	37
Сургалтын орчныг тодорхойлох.....	38
Давж заалдах	38
Давж заалдах хугацаанд хөтөлбөрт хуваарилах	39
Тусгай боловсрол, холбогдох үйлчилгээнд хамрагдах эрх үүсээгүй хүүхдийн хамгаалал.....	39
Хууль сахиулах байгууллага, шүүхэд шилжүүлэх, эдгээрээс авах арга хэмжээ	40
Эцэг эхийн шийдвэрээр хүүхдийг хувийн сургуульд төсвийн зардлаар сургах үед тавих шаардлага.....	41
Ерөнхий зүйл	41
Төсвөөс Үзүүлэх Халамжийн Тэтгэмж юм уу Даатгал Ашиглахтай Холбоотой Эцэх Эхийн Эрхийн Мэдэгдэл.....	42

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ²

УДИРТГАЛ: ПРОЦЕДУРЫН ХАМГААЛАЛТ ГЭЖ ЮУ ВЭ?

"Your Family's Special Education Rights"³ нь хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын боловсролыг дээшлүүлэх тухай хууль болох "Individuals with Disabilities Education Improvement Act of 2004" (IDEA)⁴-н гол хэсгүүдийг тодорхойлдог. IDEA 2004 хуулиар гэр бүлүүдэд тусгай боловсролын эрх, түүний дотор гэр бүл, сургууль хэрхэн асуудлыг шийдвэрлэх талаарх мэдээллээр хангахыг шаарддаг. Хэрэв танд тусгай боловсролын үйл явц ямар зарчмаар үйлчилдэг талаар асууж, дэлгэрэнгүй тодруулахыг хүсвэл VDOE⁵ -ийн Эцэг эхийн Омбудсмен 804-371- 7420 дугаарт холбогдож, өөрийн орон нутгийн тусгай боловсролын захирал, өөрийн орон нутгийн Эцэг эхийн нөөцийн төв, эсвэл Эцэг эхийн боловсролын өмгөөллийн сургалтын төв 1-800-869-6782 утсаар эсвэл цахим шуудан: partners@peatc.org хаягаар холбогдоно уу.

ТОЙМ : ТУСГАЙ БОЛОВСРОЛЫН ЗАРИМ ЧУХАЛ НЭР ТОМЬЁО

СУРГУУЛЬ хөгжлийн бэрхшээлтэй гэж тодорхойлсон, боловсролоосоо ашиг тус хүртэхийн тулд тусгай боловсрол, холбогдох үйлчилгээ хэрэгтэй сурагч бүр төрөөс үзүүлэх үнэ төлбөргүй зохистой ерөнхий боловсрол (FAPE) авах эрхтэй гэж IDEA хэлжээ.

FAPE-ийг хамгийн бага хязгаарлалттай орчинд (LRE) хангах ёстой. Энэ нь аль болох хүүхдийн боловсролын хэрэгцээг харгалзан хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүр хичээлд сууж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй бусад үйл ажиллагаанд оролцоно гэсэн үг юм.

Сурагч бүрд FAPE-г хэрхэн олгох төлөвлөгөөг жил бүр боловсруулдаг бөгөөд үүнийг Ганцаарчилсан Боловсролын Хөтөлбөр (IEP) гэж нэрлэдэг. IEP-г хүүхдийн IEP баг бичсэн бөгөөд үүнд эцэг эхийн(үүд) орно. Эцэг эхчүүд "зөвшөөрөх эрхтэй" байдаг. Энэ нь та сургууль үйл ажиллагаа явуулахаас өмнө тодорхой үйлдлүүдийг зөвшөөрөх ёстой гэсэн үг юм. IEP-ийн зорилгод хүрэхэд хүүхдүүдийнхээ гаргасан ахиц дэвшлийн тухай тайланг гэр бүлүүд тогтмол хүлээн авах ёстой.

IEP-ийг хэсэг хэсгээр нь авч үзвэл дараах зүйлс орно:

- Сурлагын амжилт, үйл ажиллагааны үзүүлэлтийн өнөөгийн түвшин,
- Тусгай тусламж, үйлчилгээ үзүүлэх тухай мэдэгдэл,
- Жил тутмын зорилго нь хэмжигдэхүйц,
- Хүүхэд тогтмол боловсролын хичээлд оролцохгүй байх хугацааны тайлбар,
- Хичээл, шалгалтад зайлшгүй хамрагдах байрны жагсаалт,
- Хүүхэд төрийн хариуцлагын тогтолцоонд, тэр дундаа SOL шалгалтад хэрхэн оролцох төлөвлөгөө.

² Энэхүү баримт бичигт байгаа заалтуудыг хамарсан IDEA-ийн хэсгийг Part B гэдэг. Энэ баримт бичигт цаашид онцгойлон тодотгох шаардлагаас бусад тохиолдолд Part-г дурдахгүй, зөвхөн IDEA гэж тодотгоно. Энэ баримт бичигт тусгай боловсролын зохицуулдаг Виржиниа мужийн хуулиудыг Виржиниагийн хууль гэж товчилж нэрлэнэ. Орч.

³ Гэр бүлүүдийн Тусгай Боловсролтой хамаарах эрхүүд- Цаашид Англи нэршилээр бичнэ. Орч.

⁴ 2004 оны Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Боловсролын Дэмжих Тухай Хууль- Цаашид IDEA гэх. Орч.

⁵ Virginia Department of Education- Виржиниа мужийн Боловсролын Яам- Цаашид VDOE гэх. Орч.

Урьдчилан бичгээр мэдэгдэх⁶

Та хүүхдийнхээ боловсролын хэрэгцээтэй хамаарах сургуулийн дүүргийн үйл ажиллагааны талаар бичгээр мэдэгдэл авах эрхтэй. Энэхүү мэдээлэл нь боловсролын шийдвэр гаргах үедээ бүрэн ойлгож зөвшөөрөл өгөхөд тусалдаг.

Мэдэгдэл

Танай сургуулийн дүүрэг дараах тохиолдлуудад тус бүрд танд бичгээр мэдэгдэх ёстой (тодорхой мэдээллийг бичгээр өгөх):

1. Хүүхдийн сургалтын хөтөлбөр, үнэлгээ, эсвэл хөтөлбөрт хамрагдсан нөхцөл шалтгаанд, эсвэл хүүхдэд төрөөс үзүүлэх үнэгүй ЕБС-н үйлчилгээнд⁷ хамрагдахтай холбоотой заалтад өөрчлөлт оруулахаар санал болгох юм уу, эсвэл өөрчлөлтийг эхлүүлэх гэж байгаа бол; **Эсвэл**
2. Хүүхдийн сургалтын хөтөлбөр, үнэлгээ, эсвэл хөтөлбөрт хамрагдсан нөхцөл шалтгаанд, эсвэл хүүхдэд төрөөс үзүүлэх үнэгүй ЕБС-н үйлчилгээнд хамрагдахтай холбоотой заалтад өөрчлөлт оруулахаас, эсвэл өөрчлөлтийг эхлүүлэхээс татгалзах тухай бүрд.

Мэдэгдлийн агуулга

Бичгээр гаргах мэдэгдэлд дараахыг тусгасан байх ёстой:

1. Тухайн сургуулийн дүүргээс санал болгож буй, эсвэл авч хэрэгжүүлэхээс татгалзаж буй арга хэмжээнүүдийг дурдах;
2. Тухайн арга хэмжээг яагаад санал болгож буй, эсвэл татгалзах болсон шалтгаан;
3. Тухайн арга хэмжээг санал болгох, эсвэл татгалзах шийдвэр гаргахдаа ашигласан үнэлгээний журам, үнэлгээ, бүртгэл, тайлан бүрийг тайлбарлан бичих;
4. IDEA хуулийн заалтын дагуу та эрхзүйн процедурын хамгаалалт авах эрхтэйг тайлбарлах
5. Хэрэв танай сургуулийн дүүргээс авахаар санал болгож буй эсвэл татгалзаж байгаа арга хэмжээ нь үнэлгээ явуулах анхны санал биш бол процедурын хамгаалалтын тодорхойлолтыг хэрхэн олж авч болохыг тайлбарлах;
6. IDEA-г ойлгоход тань туслах зорилгоор холбоо барих эх сурвалжуудыг оруулах;
7. Танай хүүхдийн Ганцаарчилсан Боловсролын Хөтөлбөр (IEP)-н багийн харгалзаж үзсэн бусад сонголтууд болон тэдгээр сонголтуудыг татгалзах болсон шалтгаануудыг тайлбарласан байх; **МӨН**

⁶ *Prior written Notice*- Сургуулийн дүүргээс хүүхдийн тусгай боловсролын хэрэгцээний талаар төлөвлөж, авч хэрэгжүүлж буй алхам үйл явцуудын тухай эцэг эх, ар гэрт урьдчилан бичгээр мэдэгдэх явц. Цаашид Урьдчилан бичгээр мэдэгдэх гэх. Орч.

⁷ *Free Appropriate Public Education (FAPE)*- Төрөөс Үзүүлэх Үнэгүй Ерөнхий Боловсролын Зохист Үйлчилгээний тухай Нууль- Цаашид FAPE гэж товчлох. Орч.

8. Танай сургуулийн дүүрэг энэ арга хэмжээг санал болгож буй эсвэл татгалзах болсон бусад үндэслэлүүдийн талаар тайлбарласан байх.

Ойлгомжтой хэлээр Мэдэгдэл хүргүүлэх

Тус мэдэгдэл нь:

1. Олон нийтэд ойлгомжтой хэлээр бичсэн байх; мөн
2. Хэрэв энэ нь огт боломжгүйгээс бусад тохиолдолд таны төрөлх хэл дээр, эсвэл таны харилцдаг өөр бусад харилцааны хэлбэрээр байх ёстой.

Хэрэв таны төрөлх хэл эсвэл бусад харилцааны арга нь бичгээр илэрхийлэх боломжгүй бол танай сургуулийн дүүрэг нь:

1. Уг мэдэгдлийг таны төрөлх хэл эсвэл таны харилцдаг өөр бусад харилцааны арга ашиглан аман орчуулга хийж хүргэх;
2. Та мэдүүлгийн агуулгыг ойлгосон байх; мөн
3. 1 ба 2-т заасныг биелүүлсэн гэдгийг бичгээр баримтжуулах үүрэгтэй.

Төрөлх хэл

Та өөрийн ойлгодог хэлээр мэдээлэл авах эрхтэй.

Англи хэлний хязгаарлагдмал мэдлэгтэй хувь хүнтэй холбоотой ашиглах үед *Төрөлх хэл* гэдэг нь дараах утгатай байна:

1. Тухайн хүний ихэвчлэн хэрэглэдэг хэл, эсвэл хүүхдийн тухайд тухайн хүүхдийн эцэг эхийн ердийн хэрэглэдэг хэл;
2. Хүүхэдтэй шууд харилцах бүхий л нөхцөлд (хүүхдийн үнэлгээ гэх мэт) нь ихэвчлэн гэр орон, суралцах орчинд хүүхдийн хэрэглэдэг хэл.

Сонсголтгүй, харалган, эсвэл бичгийн хэлгүй хүний хувьд харилцааны хэв маяг нь тухайн хүний ердийн хэрэглэдэг (дохионы хэл, брайл хэл, аман харилцаа гэх мэт) юм.

ЭЛЕКТРОН ШУУДАН

Хэрэв танай сургуулийн дүүргээс санал болговол та и-мэйлээр мэдээлэл авах сонголт хийх эрхтэй.

Хэрэв танай сургуулийн дүүрэг эцэг эхчүүдэд и-мэйлээр баримт бичиг хүлээн авах сонголтыг санал болговол та дараах зүйлсийг и-мэйлээр хүлээн авч болно. Эдгээрт:

1. Урьдчилан бичгээр мэдэгдэл;
2. Процедурын хамгаалалтын мэдэгдэл; мөн
3. Процессын эрх хангуулах хүсэлттэй холбоотой мэдэгдэл.

Аудио болон видео бичлэг

Та хүүхдийнхээ хөтөлбөрт эрх хангах эсэх, IEP, юм уу /эсвэл сахилгын асуудлыг хэлэлцэх хурал дээр аудио бичлэг хийх эрхтэй.

Тусгай боловсролын харилцааг зохицуулдаг холбооны хууль, тогтоомжууд нь эцэг эхчүүд хүүхдүүдийнхээ тусгай боловсролын хөтөлбөртэй холбоотой аудио болон видео бичлэг хийх харилцааг зохицуулах эрхийг мужуудад олгосон байдаг. Виржиниагийн тусгай боловсролын хуульд эдгээр шаардлагуудыг тодорхойлсон Процедурын Хамгаалалт хэсэгт дараах заалтуудыг оруулсан.

Та хүүхдийнхээ хөтөлбөрт эрх хангах эсэх, IEP, юм уу /эсвэл сахилгын асуудлыг хэлэлцэх хурал дээр аудио бичлэг хийх эрхтэй.

- Та хурлын өмнө сургуулийнхаа ажилтнуудад аудио бичлэг хийх тухайгаа бичгээр мэдэгдэх ёстой. Хэрэв та сургуулийн ажилтнуудад энэ тухай мэдэгдэхгүй бол аудио бичлэгийг хувилж өгөх ёстой.
- Та аудио бичлэг хийх өөрийн аудио тоног төхөөрөмж, материалыг хариуцна.
- Хэрэв сургуулийн ажилтнууд хурал дээр аудио бичлэг хийх юм уу таны аудио бичлэгийн хуулбарыг авсан нөхцөлд тухайн аудио бичлэг нь таны хүүхдийн боловсролын бүртгэлийн нэг хэсэг болно.

Сургуулийн дүүрэг нь дараах хэрэглээг хориглосон, хязгаарласан, эсвэл өөрөөр зохицуулсан журам баталж мөрдүүлж болно:

- Хурал дээр видео бичлэг хийх төхөөрөмжийн хэрэглээ; Эсвэл
- Дээр дурдсанаас бусад хурлын үеэр аудио, видео бичлэг хийх хэрэгслүүдийн хэрэглээ.

Сургуулийн дүүргийн журам нь:

- бичлэг нь хүүхдийн боловсролын бүртгэлийн нэг хэсэг болохыг зөвшөөрсөн байх.
- Тус журам нь нэгдмэл байдлаар хэрэгжих нөхцөлийг хангасан байх ёстой.

Хэрэв тус журмаар бичлэг хийх хэрэгслийн хэрэглээг хориглосон бол эцэг эх нь IEP, тусгай боловсролын үйл явцыг ойлгох эсвэл тусгай боловсролын тухай хууль, дүрэм журмаар олгогдсон эцэг, эхийн эрхээ хэрэгжүүлэхэд энэ нь зайлшгүй шаардлагатай тохиолдолд уг хоригоос чөлөөлөх боломжийг журамд тодорхой зааж өгөх ёстой.

Эцэг эхийн зөвшөөрөл – тодорхойлолт

Та мэдээлэл хуваалцах эсвэл тодорхой үйлдэл хийхийг зөвшөөрөх, эс зөвшөөрөх эрхтэй бөгөөд энэ эрхийг таны ойлгох хэл дээр танд мэдэгдэх ёстой. Та өөрийн зөвшөөрлийг буцаах (цуцлах) эрхтэй.

Зөвшөөрөл

Зөвшөөрөл гэдэг нь:

1. Та өөрийн төрөлх хэлээр эсвэл бусад хэлбэрээр (дохионы хэл, брайл хэл, амаар

харилцах гэх мэт) өөрийн зөвшөөрөл өгч буй үйл ажиллагааны талаарх бүх мэдээллийг бүрэн авч ойлгосон.

2. Та тухайн үйлдлийг ойлгож, зөвшөөрч буйгаа бичгээр гаргах бөгөөд тухай зөвшөөрөлд зөвшөөрч буй үйлдлийг, мөн (хамаарах бол) бусадтай хуваалцаж болох мэдээллийг жагсааж, эдгээр мэдээллийг хэнд шилжүүлж болохыг заасан байх; **МӨН**
3. Та зөвшөөрөл нь таны зүгээс сайн дурын байх бөгөөд зөвшөөрлөө хэзээ ч таны татан авч болохыг ойлгох. Та зөвшөөрлөө цуцалснаар та зөвшөөрөл өгсний дараа болон буцаан татахаас өмнө болсон аливаа үйлдэлд буцаан ашиглах боломжгүй.

ЭЦЭГ ЭХИЙН ЗӨВШӨӨРӨЛ

Та зөвшөөрөл олгох тодорхой эрхтэй. Жишээ нь сургууль тусгай боловсролын үйлчилгээнд таны хүүхдийг үнэлэх, тусгай боловсролтой холбоотой үйлчилгээг эхлэх, өөрчлөх юм уу зогсоох зэрэгт таны зөвшөөрлийг авах ёстой.

Анхан шатны үнэлгээний зөвшөөрөл

Танай сургуулийн дүүрэг нь дараах алхмуудыг урьдчилан гүйцэтгэхгүйгээр таны хүүхдийг IDEA хуулийн хүрээнд тусгай боловсрол болон холбогдох үйлчилгээ авах эрхтэй эсэхийг тодорхойлох анхны үнэлгээ хийхийг хориглоно. Үүнд:

1. Санал болгож буй үйл ажиллагааны талаар урьдчилан бичгээр мэдэгдэх; мөн
2. Таны зөвшөөрлийг авах зэрэг болно.

Танай сургуулийн дүүрэг таны хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тодотгох шийдвэр гаргах үүднээс анхны үнэлгээ хийхээс өмнө энэ тухай танилцаж ойлгосон тухай таны зөвшөөрлийг авахын тулд зохих хүчин чармайлт гаргах ёстой.

Анхны үнэлгээ явуулах таны зөвшөөрөл нь сургуулийн дүүрэг таны хүүхдэд тусгай боловсрол болон үүнтэй холбогдох үйлчилгээ үзүүлж эхлэх зөвшөөрөл өгсөн гэсэн үг биш юм.

Хэрэв таны хүүхэд улсын сургуульд сурч байгаа эсвэл та хүүхдээ улсын сургуульд бүрдгүүлэх гэж байгаа бөгөөд та зөвшөөрөл өгөхөөс татгалзсан эсвэл анхны үнэлгээ хийх зөвшөөрөл авах хүсэлтэд хариу өгөөгүй бол танай сургуулийн дүүрэг хэрэв шаардлагатай гэж үзвэл энэ баримт бичигт хожим тайлбарлах зуучлал эсвэл зохих үйл явцын журмыг ашиглан хүүхдэд анхны үнэлгээ хийх санаачилга гаргаж болно. Хэрэв ийм нөхцөл байдлын улмаас хүүхдэд үнэлгээ хийхгүй байхаар шийдэх нь танай сургуулийн дүүрэг хүүхдийг олж, тодорхойлох, үнэлэх үүргээ зөрчсөнд тооцогүй.

Төрийн асрамжид буй хүүхдийн Анхан Шатны Үнэлгээний Тусгай Журам

[Хэрэв хүүхэд төрийн хамгаалалтад байгаа бөгөөд эцэг/эхтэйгээ хамт амьдрахгүй байгаа бол]

Дараах тохиолдлуудад хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоохын тулд эцэг эхээс нь зөвшөөрөл авах шаардлагагүй. Эдгээрт:

1. Зохих хүчин чармайлт гаргасан хэдий ч сургуулийн дүүрэг хүүхдийн эцэг эхийг олж чадаагүй;
2. Эцэг, эхийн эрхийг мужийн хуулийн дагуу цуцалсан; **Эсвэл**
3. Шүүхээс боловсролын шийдвэр гаргах, анхан шатны үнэлгээ хийх зөвшөөрөл

олгох эрхийг эцэг эхээс бусад этгээдэд оноосон бол.

Төрийн асрамжид буй хүүхэд гэдэг нь IDEA хульд зааснаар хүүхдийн оршин суугаа мужаас хамаарч дараах нөхцөлийг илэрхийлнэ:

1. Асрамжийн газарт байгаа хүүхэд;
2. Мужийн хуулийн дагуу төрийн хамгаалалтад байгаа гэж үзсэн; **Эсвэл**
3. Хүүхэд хамгааллын төрийн байгууллагын хяналтад байгаа.

Бусдын түр асрамжид байгаа хүүхдийг *төрийн асрамжид* байгаа гэж үзэхгүй.

Үйлчилгээ үзүүлэх Эцэг Эхийн Зөвшөөрөл

Сургуулийн алба нь таны хүүхдэд анх удаа тусгай боловсрол болон үүнтэй холбогдох үйлчилгээ үзүүлэхийн өмнө танаас энэ тухай танилцаж ойлгосон тухай зөвшөөрлийг авахын тулд зохих хүчин чармайлт гаргах ёстой.

Хэрэв та хүүхдээ анх удаа тусгай боловсрол болон холбогдох үйлчилгээ авахад нь зөвшөөрөл авах хүсэлтэд хариу өгөөгүй, эсвэл ийм зөвшөөрөл өгөхөөс татгалзсан тохиолдолд таны сургуулийн дүүрэг тусгай боловсрол болон үүнтэй холбогдох үйлчилгээг (таны хүүхдийн IEP баг санал болгосон) таны хүүхдэд таны зөвшөөрөлгүй үзүүлж болно гэсэн тохиролцоо, шийдвэрийг гаргуулахад зуучлах юм уу эрхзүйн процессыг ашиглахгүй байж болно.

Хэрэв та хүүхдээ анх удаа тусгай боловсрол, холбогдох үйлчилгээ авах зөвшөөрлийг өгөхөөс татгалзсан, эсвэл ийм зөвшөөрөл авах хүсэлтэд хариу өгөөгүй улмаар сургуулийн дүүрэг таны зөвшөөрөл шаардагдах тусгай боловсрол, түүнтэй холбоотой үйлчилгээг таны хүүхдэд үзүүлээгүй бол, танай сургуулийн дүүрэг:

1. Таны хүүхдэд эдгээр үйлчилгээг үзүүлж чадаагүй нь хүүхдэд төрөөс үзүүлэх зохист боловсролын үйлчилгээг үнэ төлбөргүй олгох (FAPE) хуулийн үүргийг зөрчсөнд тооцохгүй; **МӨН**
2. Таны зөвшөөрөл шаардагдсан тусгай боловсрол, холбогдох үйлчилгээнд зориулж Ганцаарчилсан Боловсролын Хөтөлбөр (IEP)-н хурал хийх эсвэл хүүхдэд зориулж IEP-г төлөвлөх үүрэг хүлээхгүй.

Дахин үнэлгээний эцэг эхийн зөвшөөрөл

Сургуулийн дүүрэг дараах нөхцөлүүдийг баримтжуулах боломжтойгоос бусад тохиолдолд танай сургуулийн дүүрэг таны хүүхдийг дахин үнэлэхээс өмнө энэ тухай танилцаж ойлгосон тухай таны зөвшөөрлийг авах ёстой. Эдгээрт:

1. Дүүргээс таны хүүхдэд дахин үнэлгээ хийх зөвшөөрөл авахын тулд зохих алхмуудыг хийсэн; **бөгөөд**
2. Та хүсэлтэд хариу өгөөгүй.

Энэ нөхцөлд сургуулийн дүүрэг дахин үнэлгээний үйл явцыг үргэлжлүүлнэ.

Хэрэв та хүүхдэд дахин үнэлгээ хийх зөвшөөрөл олгохоос татгалзсан нөхцөлд сургуулийн дүүрэг хэдийгээр ийм үүрэг хүлээхгүй боловч шаардлагатай гэж үзвэл таны хүүхдэд дахин үнэлгээ хийхээс татгалзсаныг үл харгалзан зуучлах журам, эсвэл зохих эрхзүйн үйл явцыг ашиглан хүүхдэд дахин үнэлгээ хийх хүчин чармайлт гаргаж болно. Анхан шатны

үнэлгээний нэгэн адил танай сургуулийн дүүрэг дахин үнэлгээг ийнхүү хийхээс татгалзвал IDEA-ийн дагуу хүлээсэн үүргээ зөрчсөнд тооцохгүй.

Эцэг Эхийн Зөвшөөрөл Авах Хүчин Чармайлтыг Баримтжуулах

Сургуулийн дүүрэг нь анхан шатны үнэлгээ хийх, тусгай боловсрол болон холбогдох үйлчилгээг анх удаа үзүүлэх, давтан үнэлгээ хийхэд эцэг эхийн зөвшөөрөл хүсэх, анх удаа үйлчилгээ үзүүлэх төрийн асрамжид буй хүүхдийн эцэг эхийг олж тогтоох алхмуудыг баримтжуулах ёстой. Эдгээр чиглэлд сургуулийн дүүргээс хийсэн оролдлогуудыг бүртгэлд дараах байдлаар тусгана. Тухайлбал:

1. Утсаар ярьсан буюу ярихыг оролдсон дэлгэрэнгүй бүртгэл, тэдгээр дуудлагын үр дүн;
2. Эцэг эхчүүдэд илгээсэн захидлын хуулбар болон хүлээн авсан аливаа хариулт; **МОН**
3. Эцэг эхийнх нь гэрт эсвэл ажлын газарт очсон тэмдэглэл болон тэдгээр биечилж очсон тохиолдлуудын үр дүнгийн тухай дэлгэрэнгүй тэмдэглэл.

Зөвшөөрлөө Цуцлах

Та хүүхдийнхээ тусгай боловсрол, холбогдох үйлчилгээг үргэлжлүүлэн авах зөвшөөрлийг хэзээ ч цуцлах эрхтэй. Ийнхүү зөвшөөрлийг хүчингүй болгох нь таны хүүхдийн авч байгаа бүх тусгай боловсрол, холбогдох үйлчилгээнд хамаарна. Хэрэв та ямар нэг үйлчилгээний талаар санал зөрөлдсөн бол энэ асуудлыг хүүхдийнхээ IEP багтай ярилцаж болох бөгөөд хэрэв асуудал шийдэгдэхгүй хэвээр байвал зуучлал, зохих эрхзүйн үйл явц нь асуудлыг шийдвэрлэх боломжит хувилбарууд байж болох юм.

- Та энэхүү хүсэлтийг орон нутгийнхаа тусгай боловсролын захирал, хүүхдийнхээ захирал эсвэл хүүхдийнхээ IEP зохицуулагчид бичгээр өгөх ёстой.
- Үүний дараа танай сургуулийн дүүрэг таны хүүхдэд зориулсан үйлчилгээг зогсоохоос өмнө энэ тухай урьдчилан бичгээр мэдэгдэх ёстой.
- Танай сургуулийн дүүрэг таны бодол санааг өөрчлөхийг оролдох эсвэл сонсголын офицерыг шийдвэрийн тань эсрэг шийдвэр гаргахад зуучлах эсвэл эрхзүйн зохих үйл явцыг ашиглахгүй байж болно.
- Танай сургуулийн дүүрэг таны хүүхдэд зориулсан үйлчилгээг зогсоохыг хүссэн шалтгаанаа тайлбарлахыг шаардахгүй байж болно.
- Хэрэв та хожим нь бодлоо өөрчилж, хүүхдэдээ дахин үйлчилгээ авахыг хүсвэл танай сургуулийн дүүрэг үүнийг давтан үнэлгээ биш харин анхны үнэлгээний журмаар хянаж шийдвэрлэнэ.

Таны зөвшөөрөл цуцлах хүсэлт хэрэгжиж эхэлмэгц;

- Таны хүүхдийг хөгжлийн бэрхшээлгүй сурагчидтай адил гэж үзэх бөгөөд хэрэв хамаарах бол хөгжлийн бэрхшээлгүй сурагчдад хамрах үйлчилгээнд хамрагдана.
- Таны хүүхдийн IEP хүчингүй болно.

- Таны хүүхэд хөгжлийн бэрхшээлгүй сурагчдын сахилга батын дүрэм журам мөрдөнө.
- Хэрэв таны хүүхэд “Modified Diploma” авахаар төлөвлөж авч байсан бол таны хүүхэд энэ дипломын сонголтыг хийх эрхгүй болно. Таны хүүхэд диплом авахын тулд энгийн дипломын бүх нөхцөл шаардлагуудыг хангах хэрэгтэй болно.

Зөвшөөрлийн бусад шаардлага

Виржиниа мужид дараах үйлдлүүдийг хийхийн тулд таны зөвшөөрөл шаардлагатай:

- Таны хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн тодорхойлолтод болон таны хүүхдийн IEP-д ямар нэгэн өөрчлөлт оруулах
- Таны хүүхдийн тусгай боловсрол, холбогдох үйлчилгээнд хамрагдах эрхэд ямар нэгэн өөрчлөлт оруулах; мөн
- Таны хүүхэд стандарт юм уу ахисан түвшний дипломтой төгссөнөөс бусад тохиолдолд тусгай боловсрол, түүнтэй холбоотой үйлчилгээг хэсэгчлэн эсвэл бүрэн зогсоох зэрэг.

Дараах тохиолдлуудад сургуулийн дүүрэг таны зөвшөөрлийг шаардахгүй байж болно:

1. Хүүхдийн үнэлгээний явцад юм уу давтан үнэлгээний хүрээнд өмнө нь авагдсан мэдээллийг хянах; **Эсвэл**
2. Шалгалтаас өмнө бүх хүүхдийн эцэг эхээс зөвшөөрөл авах шаардлагатайгаас бусад тохиолдолд хүүхдээс бусад бүх хүүхдээс авах шалгалтыг авах.

Та нэг үйлчилгээ юм уу арга хэмжээнд зөвшөөрөл өгөхөөс татгалзах нь танай сургуулийн дүүрэг танд болон танай хүүхдэд өөр бусад үйлчилгээ юм уу арга хэмжээнд оролцуулахаас татгалзах үндэслэл болохгүй байж болно.

Хэрэв танай хүүхэд өөрсдийн зардлаар хувийн сургуульд сурч байгаа, эсвэл гэрээр сурч байгаа бөгөөд хүүхдийнхээ анхны үнэлгээ болон давтан үнэлгээнд зөвшөөрөл өгөөгүй, эсвэл таны зөвшөөрлийг авах хүсэлтэд хариу өгөөгүй бол сургуулийн дүүрэг бусад эрхзүйн боломж (зуучлал, зохих эрхзүйн үйл явцын журам г.м) ашиглан үйлчилгээ үзүүлэх үүрэг хүлээхгүй бөгөөд хүүхэд тэгш эрхтэй үйлчилгээ (эцэг эхийн зардлаар хувийн сургуульд сурч буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд үзүүлэх үйлчилгээ) авах эрхтэй гэж үзэх хариуцлага хүлээхгүй.

Зөвшөөрөл – Түр асран хамгаалагч эцэг эхчүүдэд зориулсан тусгай шаардлага

Хэрэв таны хүүхэд түр асран хамгаалагч эцэг эхтэй хамт амьдарч байгаа бөгөөд таны эцэг эхийн эрхийг цуцлаагүй бол танай сургуулийн дүүрэг танд сургуулийн ажилтнууд таны хүүхдийн тусгай боловсролын хөтөлбөрийн талаар шийдвэр гаргахын тулд түр асран хамгаалагч эцэг эхийн шийдвэрийг харгалзах тухай мэдэгдлийг бичгээр мэдэгдэх ёстой. Эдгээр шийдвэрүүдэд таны хүүхдийн IEP үйлчилгээ, хөтөлбөр/ анги хуваарилалттай холбоотой асуудлууд, мөн хөтөлбөрт эрх хангах эсэх шийдвэрүүд хамаарна.

Сургуулийн дүүрэг энэ мэдэгдлийг хичээлийн жилийн эхэнд юм уу эсвэл хичээлийн жилийн явцад танай хүүхдийн IEP буюу тусгай боловсрол, холбогдох үйлчилгээнд хамрагдахтай холбоотой хурал болсон даруйд танд бичгээр мэдэгдэх болно. Та хүүхдийнхээ тусгай боловсролын хөтөлбөртэй холбоотой асуудлаар хүүхдийнхээ төрүүлсэн эцэг эх юм уу эсвэл үрчилж авсан эцэг эхийн хувиар хариу өгөх хүртэл сургуулийн дүүргийн энэхүү

мэдэгдэл хүчин төгөлдөр хэвээр байна. Тиймээс сургуулийн дүүрэгт байгаа таны шуудангийн хаяг, холбоо барих мэдээлэл хүчинтэй зөв байгаа эсэхийг шалгаарай.

Сурагчдын шилжилт– Хэрэв та нүүвэл юу болох вэ?

Хэрэв танай гэр бүл Виржиниа муж дотор өөр сургуулийн дүүрэг рүү нүүсэн эсвэл та өөр мужаас Виржиниа мужид нүүж ирсэн бол хүүхдийн шинэ сургууль дээр хүүхдийн IEP-г үргэлжлүүлэхийн тулд сургуулийн дүүргээс таны зөвшөөрлийг нэн даруй шаардахгүй байж болно. Гэсэн хэдий ч шинэ сургуулийн дүүрэг нь танай хүүхэд тусгай боловсрол, түүнтэй холбоотой үйлчилгээгээ хэвийн үргэлжлүүлэн авч байгаа эсэх талаар тантай зөвлөлдөж болох бөгөөд хүүхдийн IEP-д тусгасан үйлчилгээтэй дүйхүйц үйлчилгээ авч байгаа эсэхэд хяналт тавьж ажиллана.

- Танай сургуулийн шинэ дүүргээс өмнөх сургуулийн дүүрэгтэй холбоо барьж, хүүхдийн тусгай боловсролын үйлчилгээ, түүнтэй холбогдох бусад үйлчилгээтэй холбогдох бичиг баримтуудыг шилжүүлж авахын тулд бүхий л хүч чармайлтыг гаргаж ажиллана. Үүний үр дүнгээс хамаарч сургуулийн шинэ дүүрэг дараах сонголтуудын аль нэгийг сонгож шийдэх болно. Үүнд:
 - ✓ Таны зөвшөөрлөөр өмнөх IEP-г шилжүүлэн авч хэрэгжүүлэх, эсвэл
 - ✓ Шинэ IEP боловсруулахад шаардлагатай мэдээллийг олж авч, хянах явцад таны зөвшөөрлөөр түр IEP-г боловсруулж хэрэгжүүлэх, эсвэл
 - ✓ Таны зөвшөөрлөөр үнэлгээ хийж, шинэ IEP-г боловсруулж, хэрэгжүүлэх.
- Хэрэв та болон сургуулийн ажилтнууд түр үйлчилгээ эсвэл шинэ IEP-ийн талаар санал зөрүүтэй бол та болон/эсвэл танай сургуулийн шинэ дүүрэг зуучлах юм уу эсвэл эрхзүйн зохих үйл явцаар маргааныг шийдвэрлэх хувилбаруудыг эхлүүлж болно. Маргаан шийдвэрлэх явцад танай сургуулийн шинэ дүүрэг тантай зөвлөлдөж хүүхдэд FARE-н үйлчилгээг тасралтгүй үзүүлэх бөгөөд өмнөх сургуулийн дүүргээс баталсан хүүхдийн IEP-д тусгагдсан үйлчилгээтэй дүйхүйц үйлчилгээг үзүүлнэ.

БИЕ ДААСАН БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭ

Хэрэв та сургуулийн дүүргийн гүйцэтгэсэн үнэлгээтэй санал нийлэхгүй бол тухайн сургуулийн дүүрэгтэй хамааралгүй этгээдээр хүүхдийн үнэлгээг сургуулийн дүүргийн зардлаар дахин хийлгэх эрхтэй.

Ерөнхий

Доор дурдсанчлан та өөрийн сургуулийн дүүргээс хийсэн хүүхдийнхээ үнэлгээтэй санал нийлэхгүй бол хөндлөнгийн бие даасан боловсролын үнэлгээ (IEE) хийлгэх эрхтэй.

Хэрэв та бие хөндлөнгийн бие даасан боловсролын үнэлгээ хийлгэх хүсэлт гаргавал сургуулийн дүүрэг нь танд бие даасан боловсролын үнэлгээг хаанаас авч болох талаар болон бие даасан боловсролын үнэлгээнд тавигдах сургуулийн дүүргийн нөхцөл шалгуурын талаар мэдээлэл өгөх ёстой.

Тодорхойлолтууд

Бие даасан боловсролын үнэлгээ гэдэг нь таны хүүхдийн боловсролын асуудал хариуцсан сургуулийн дүүрэгт ажилладаггүй, мэргэшсэн үнэлгээчний хийсэн үнэлгээг хэлнэ.

Төсвийн зардал гэдэг нь сургуулийн дүүрэг үнэлгээний зардлыг бүрэн төлж барагдуулах юм уу эсвэл IDEA хуулиар тус хуулийн заалтын хэрэгжилтийг хангахын тулд муж, орон нутаг, холбооны юм уу хувийн сургуулиудад зөвшөөрсөн зохицуулалтаар үнэлгээг танд үнэ төлбөргүй олгох зохицуулалтыг хэлнэ.

Үнэлгээг төсвийн зардлаар гаргуулах эцэг, эхийн эрх

Хэрэв та сургуулийн дүүргийн гүйцэтгэсэн үнэлгээтэй санал нийлэхгүй бол хөндлөнгийн бие даасан боловсролын үнэлгээг төсвийн зардлаар хийлгэх эрхтэй бөгөөд үүнд дараах нөхцөл журам үйлчилнэ:

1. Хэрэв та хөндлөнгийн бие даасан боловсролын үнэлгээг төсвийн зардлаар хийлгэх хүсэлт гаргасан бол танай сургуулийн дүүрэг дараахын аль зохихыг ямар нэгэн зайлшгүй хүндэтгэх шалтгаантай биш бол нэн даруй хэрэгжүүлнэ: (а) хүүхдэд явуулсан үнэлгээ нь зохистой гэдгийг нотлох сонсгол явуулахаар эрхзүйн зохих процессын хүрээнд хүсэлтийг албан ёсоор гаргах, эсвэл (б) таны олж авсан хүүхдийн үнэлгээ нь тус сургуулийн дүүргээс тавигдах нөхцөл шаардлагад нийцэхгүй гэдгийг сургуулийн дүүрэг сонсголын үеэр нотолсноос бусад нөхцөлд хөндлөнгийн бие даасан үнэлгээг төсвийн зардлаар гүйцэтгэнэ.
2. Хэрэв тухайн сургуулийн дүүрэг сонсгол явуулах хүсэлт гаргаж, улмаар сонсголын эцсийн дүгнэлтээр хүүхдийн үнэлгээ хүчинтэй гэж үзсэн нөхцөлд эцэг эхийн хөндлөнгийн бие даасан боловсролын үнэлгээ хийлгэх эрх нээлттэй хэвээр байх бөгөөд харин зардлыг төсвөөс хариуцахгүй.
3. Хэрэв та хөндлөнгийн бие даасан боловсролын үнэлгээ хийлгэх хүсэлт гаргасан нөхцөлд тухайн сургуулийн дүүрэгт байгаа хүүхдийн үнэлгээтэй яагаад санал нийлэхгүй байгааг танаас асууж болно. Харин энэ талаар тайлбар шаардахгүй бөгөөд хөндлөнгийн бие даасан боловсролын үнэлгээг төсвийн зардлаар гүйцэтгэх юм уу сургуулийн дүүргээс хүүхдэд явуулсан үнэлгээгээ хамгаалах сонсгол явуулахаар эрхзүйн зохих процессын хүрээнд хүсэлтийг албан ёсоор гаргах алхмуудын аль нэгийг зайлшгүй хүндэтгэх шалтгаантай биш бол нэн даруй хэрэгжүүлж эхэлнэ.

Таны санал нийлээгүй сургуулийн дүүргээс гаргасан хүүхдийн үнэлгээ тус бүрд зөвхөн нэг удаа хөндлөнгийн бие даасан боловсролын үнэлгээг төсвийн зардлаар гүйцэтгүүлэх эрхтэй байна.

Үнэлгээг эцэг эхийн санаачилгаар эхлүүлэх

Хэрэв та хүүхдийнхээ үнэлгээг бие даасан боловсролын үнэлгээний байгууллагаар төсвийн зардлаар гүйцэтгүүлж үр дүнг авсан бол эсвэл өөрийн зардлаар хийлгэсэн үнэлгээг сургуулийн дүүрэгт хүлээлгэн өгсөн нөхцөлд:

1. Хэрэв тухай үнэлгээ нь сургуулийн дүүргээс тавьдаг нөхцөл шаардлагад нийцсэн гэж үзвэл танай хүүхдэд төрөөс үзүүлэх зохист үнэ төлбөргүй боловсролын үйлчилгээ (FAPE) үзүүлэхтэй холбоотой аливаа шийдвэрт тухайн үнэлгээний үр дүнг ашиглах, **МӨН**
2. Та юм уу эсвэл сургуулийн дүүрэг нь таны хүүхэдтэй холбоотой эрхзүйн процессын хүрээнд явагдах сонсгол дээр тухайн үнэлгээг баримт болгож ашиглаж болно.

Сонсгол Хариуцсан Албан Хаагчаас Үнэлгээ Гаргах Хүсэлт

Хэрэв сонсгол хариуцсан ажилтнаас эрхзүйн процессын хүрээнд явагдах сонсголд шаардлагатай гэж үзэн хүүхдэд бие даасан боловсролын үнэлгээ явуулахыг хүссэн нөхцөлд үнэлгээг зөвхөн төсвийн зардлаар гүйцэтгэнэ.

Сургуулийн дүүргийн шалгуур үзүүлэлт

Хэрэв бие даасан боловсролын үнэлгээг төсвийн зардлаар хийлгэх бол, үнэлгээ хийх байршил, үнэлгээний мэргэшил зэрэгт тавигдах шаардлага нь сургуулийн дүүргийн үнэлгээ хийх үед ашигладаг шаардлагатай адил байх ёстой (таны бие даасан үнэлгээ хийлгэх эрхтэй нийцсэн тохиолдолд).

Дээр дурдсан шалгуураас бусад тохиолдолд сургуулийн дүүрэг нь төсвийн зардлаар бие даасан боловсролын үнэлгээ авахтай холбоотой нөхцөл, хугацааг тогтоож болохгүй.

МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛ

Виржиниа мужийн “Management of Student Scholastic Records,” баримт бичгийг үзэх: <https://www.doe.virginia.gov/?navid=257>.

Тодорхойлолтууд

Мэдээллийн нууцлал гарчгийн дор ашиглагддаг ойлголтууд:

- *Устгах* гэдэг нь мэдээллийг биечлэн устгах буюу хувь хүнийг таних боломжтой мэдээллийг арилгахыг хэлнэ. Ингэснээр тухайн мэдээллийг хувь хүнтэй холбоотойгоор таних боломжгүй болно.
- *Боловсролын бүртгэл* гэдэг нь 1974 оны Гэр бүлийн боловсролын эрх ба нууцлалын тухай хууль (FERPA), 20 U.S.C. 1232g-д заасан боловсролын бүртгэлийн тодорхойлолтыг хэрэгжүүлдэг 34 CFR 99-р хэсэгт хамаарах төрөл бүрийн бүртгэлийг хэлнэ.

Хувь хүнийг таних мэдээлэл

Хувь хүнийг таних боломжтой гэдэгт дараах мэдээллийг хэлнэ:

- Таны хүүхдийн нэр, таны нэр эсвэл гэр бүлийн бусад гишүүний нэр;
- Таны хүүхдийн хаяг;
- Таны хүүхдийн нийгмийн даатгалын дугаар эсвэл сурагчийн дугаар зэрэг хувь хүний таних тэмдэг; **эсвэл**
- Таны хүүхдийг тодорхойлох боломжтой хувийн шинж чанарууд эсвэл бусад мэдээллүүд.

Эцэг эхчүүдэд өгөх мэдэгдэл

Таны хүүхдийн мэдээллийг муж болон орон нутгийн сургуулийн дүүрэгт хэрхэн ашиглаж, нууцлалыг хэрхэн хангаж байгаа талаарх мэдээлэл авах эрхтэй.

Виржиниа Мужийн Боловсролын Яам (VDOE) хувь хүнийг таних боломжтой мэдээллийн нууцлалыг бүрэн ойлгуулах зорилгоор эцэг эхчүүдэд хангалттай мэдэгдэл өгөх ёстой, үүнд:

1. Виржиниад амьдарч буй янз бүрийн хүн амын бүлгүүдийн төрөлх хэл дээр мэдэгдэл өгч байгаа цар хүрээг тайлбарлах;
2. Хувь хүнийг таних боломжтой мэдээлэл нь хадгалагдаж байгаа хүүхдүүдийн тухай, ямар төрлийн мэдээллийг авахыг хүсэж байгаа, Виржиниа мэдээлэл цуглуулахдаа ямар арга ашиглах (үүнд мэдээлэл цуглуулах эх сурвалжууд орно), мөн цуглуулсан мэдээллийг хэрхэн ашиглах талаар тайлбарлах;
3. Оролцогч байгууллагууд хувь хүнийг таних боломжтой мэдээллийг хадгалах, гуравдагч этгээдэд мэдээлэх, хадгалах хугацаа, устгахтай холбоотой мөрдөх бодлого, журмын хураангуй;
4. Энэхүү мэдээлэлтэй холбоотой эцэг эх, хүүхдүүдийн бүх эрхийн тайлбар, үүнд Гэр бүлийн боловсролын эрх ба нууцлалын тухай хууль (FERPA) болон түүнийг хэрэгжүүлдэг 34 CFR 99-р хэсгийн дагуу эрхүүдийг тайлбарлах.

Аливаа томоохон хүүхдийг танин илрүүлэх, олж тогтоох, үнэлэх үйл ажиллагаа ("child find" гэж нэрлэдэг) хийхээс өмнө сургуулийн дүүргүүд хүүхдийг тусгай боловсрол, холбогдох үйлчилгээ шаардлагатай байгаа хүүхдүүдийг таних, илрүүлэх, үнэлэх үйл ажиллагааны талаар эцэг эхчүүдэд мэдэгдэхийн тулд олон нийтэд хангалттай хүртээлтэй сонин эсвэл бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлах ёстой.

Мэдээлэлд Нэвтрэх Эрх

Та хүүхдийнхээ бүртгэлийг хянах эрхтэй.

Танай сургуулийн дүүрэг⁸ IDEA-ийн дагуу танай сургуулийн хэлтэст цуглуулсан, хадгалсан эсвэл ашигладаг таны хүүхэдтэй холбоотой аливаа боловсролын бүртгэлийг шалгаж, хянахыг танд зөвшөөрөх ёстой. Сургуулийн дүүрэг таны өөрийн хүүхдийн боловсролын бүртгэлийг шалгаж, хянах хүсэлтийг Ганцаарчилсан Боловсролын Хөтөлбөр (IEP)-тэй холбоотой аливаа уулзалтын өмнө, эсвэл эрхзүйн процессын хүрээний сонголт (шийдвэр гаргах хурал, сахилга батын сонголт зэрэг)-ын өмнө ямар нэгэн хүндэтгэх шалтгаангүй бол хойшлуулалгүйгээр биелүүлэх ёстой бөгөөд хүсэлт гаргаснаас хойш хуанлийн 45 хоногоос хэтрэхгүй хугацаанд биелүүлэх үүрэгтэй.

Таны боловсролын бүртгэлийг шалгах, хянах эрхэд дараах зүйлс хамаарна:

1. Тухайн бүртгэлийн утга, үүнийг тайлбарлахыг хүссэн таны зүй ёсоор гаргасан хүсэлтэд сургуулийн дүүргээс хариу авах эрх;
2. Хэрэв та бүртгэлийн хуулбарыг хүлээн аваагүй бол бүртгэлийг үр дүнтэй шалгаж, хянаж чадахгүй бол сургуулийн дүүргээс бүртгэлийн хуулбарыг гаргаж өгөхийг шаардах эрх; **болон**
3. Бүртгэлийг өөрийн төлөөлөгчөөр шалгуулж, хянуулах эрхтэй.

Хүүхэд асран хамгаалах эрх, гэр бүлийн салалт, гэр бүл цуцлалт зэрэг харилцааг зохицуулдаг Виржиниа мужийн холбогдох хуулийн дагуу таныг бүртгэл шаардах эрхгүй гэж үзсэнээс

⁸ Бүрдгэлтэй холбоотой эдгээр заалт нь "оролцогч агентлагуудад" хамаарна. "Оролцогч агентлаг" гэж IDEA-ийн В хэсгийн дагуу хувийн мэдээллийг цуглуулдаг, хадгалдаг, ашигладаг, эсвэл мэдээлэл олж авдаг аливаа сургуулийн хэлтэс, агентлаг, байгууллагыг хэлнэ. Гэсэн хэдий ч энэхүү баримт бичиг нь орон нутгийн сургуулийн хэлтэстэй эцэг эхийн оролцоонд анхаарлаа хандуулдаг тул "оролцогч агентлаг" гэхээсээ илүү "орон нутгийн сургуулийн хэлтэс" гэсэн нэр томъёог ашигладаг

бусад тохиолдолд сургуулийн дүүрэг нь таныг хүүхэдтэй холбоотой бүртгэлийг шалгах, хянах эрхтэй гэж үзнэ.

БҮРТГЭЛД НЭВТЭРСЭН ХАРИЛЦААГ БҮРТГЭХ

Хэрэв таны хүүхдийн боловсролын бүртгэлийг танаас өөр хэн нэгэн эсвэл сургуулийн дүүргийн ажилтан үзсэн бол тухайн хүүхдийн бүртгэлийг хариуцдаг сургууль нь хүүхдийн бүрдгэлд хэн нэвтэрсэн, хэзээ, яагаад хянасан тухай тэмдэглэл хөтөлж байх ёстой.

Сургуулийн хэлтэс бүр IDEA-ийн дагуу цуглуулсан, хадгалсан эсвэл ашигласан боловсролын бүртгэлд нэвтрэх эрх авсан талуудын бүртгэлийг, (эцэг эх, сургуулийн дүүргийн эрх бүхий ажилтнууд нэвтэрснээс бусад) тухайлбал талуудын нэр, нэвтрэх эрх олгосон огноо, ямар зорилгоор тухайн этгээдэд бүртгэлийг ашиглах эрх олгосон зэргийг хөтлөх ёстой.

Нэгээс дээш хүүхдийн бүртгэл

Хэрэв боловсролын ямар нэг бүртгэлд нэгээс дээш хүүхдийн мэдээлэл багтсан бол тэдгээр хүүхдийн эцэг, эх нь зөвхөн хүүхэдтэйгээ холбоотой мэдээллийг үзэж, шалгах эсвэл тэрхүү тодорхой мэдээллээр хангагдах эрхтэй.

Мэдээллийн төрөл, байршлын жагсаалт

Хүсэлтийн дагуу сургуулийн дүүрэг бүр тухай байгууллагад цугларсан, хадгалагдаж байгаа эсвэл ашиглаж буй боловсролын бүртгэлийн төрөл, байршлын жагсаалтыг танд өгөх ёстой.

Хураамж

Сургуулийн хэлтэс бүр IDEA-ийн дагуу танд зориулж хийсэн бүртгэлийн хуулбарыг олгохдоо энэ нь эцэг эхийн тухайн бүртгэлийг шалгах, хянах эрхээ хэрэгжүүлэхэд шууд саад болохооргүй бол хураамж авч болно.

Сургуулийн дүүрэг нь IDEA-ийн дагуу мэдээлэл хайх, олж авахад төлбөр авахгүй.

Эцэг эхийн хүсэлтээр бүртгэлд өөрчлөлт оруулах тухай

Хэрэв бүртгэл буруу юм уу эсвэл энэ нь хүүхдийн нууцлалд сөрөг нөлөөлнө гэж үзсэн нөхцөлд та хүүхдийн боловсролын бүртгэлийг өөрчлөх хүсэлт гаргах эрхтэй.

Хэрэв та IDEA-ийн дагуу цуглуулсан, хадгалсан, ашигласан хүүхдийнхээ талаарх боловсролын бүртгэлд байгаа мэдээлэл нь буруу, төөрөгдүүлсэн, таны хүүхдийн хувийн нууц болон бусад эрхийг зөрчсөн гэж үзэж байгаа бол мэдээллийг хадгалж буй сургуулийн хэлтэст өөрчлөлт оруулах хүсэлт гаргаж болно.

Сургуулийн хэлтэс таны хүсэлтийг хүлээн авснаас хойш боломжит хугацаанд таны хүсэлтийн дагуу мэдээллийг өөрчлөх эсэхийг шийдэх ёстой.

Сургуулийн хэлтэс нь таны хүсэлтийн дагуу мэдээллийг өөрчлөхөөс татгалзвал, татгалзсан тухайгаа мэдэгдэж, **Сонголд Орох Боломж** гарчигт дурдсанчлан энэ зорилгоор сонгогч хийх эрхийн талаар танд мэдэгдэх ёстой.

СОНГОЛД ОРОЛЦОХ БОЛОМЖ

Хүүхдийнхээ боловсролын бүртгэлийг өөрчлөх хүсэлтийг тань татгалзвал та сонгогч хийх эрхтэй.

Сургуулийн дүүрэг нь хүсэлтийн дагуу таны хүүхдийн талаарх боловсролын бүртгэлд байгаа мэдээлэл нь буруу, төөрөгдүүлсэн, таны хүүхдийн хувийн нууц болон бусад эрхийг зөрчөөгүй эсэхийг шалгах сонгогч хийх боломжийг танд олгох ёстой.

СОНГОЛ ЯВУУЛАХ ЖУРАМ

Боловсролын бүртгэл дэх мэдээллийг нягтлан шалгах сонгогчдыг Гэр бүлийн боловсролын эрх, нууцлалын тухай хуулийн (FERPA) дагуу ийм сонгогчдын журмын дагуу явуулах ёстой.

Виржиниа мужид сургуулийн дүүргүүд энэхүү баримт бичгийн "Эрхзүйн процессын Журам" хэсэгт тайлбарласны дагуу сонгогчдын журмуудыг ашиглах, эсвэл FERPA-тай нийцэж байгаа тохиолдолд бие даасан журам гаргаж мөрдөх боломжтой.

СОНГОЛЫН ҮР ДҮН

Та сонгогчдын үр дүнд хүүхдийнхээ боловсролын бүртгэлд өөрчлөлт оруулах эсвэл бүртгэлд байгаа мэдээлэлтэй санал нийлэхгүй байгаа тухай мэдэгдлийг боловсролын бүртгэлд оруулах эрхтэй

Хэрэв сонгогчдын үр дүнд мэдээлэл буруу ташаа, эсвэл таны хүүхдийн хувийн нууц, бусад эрхийг зөрчсөн нь тогтоогдвол тухайн сургуулийн дүүрэг мэдээлэлд өөрчлөлт оруулж, танд бичгээр мэдэгдэх ёстой.

Хэрэв сонгогчдын үр дүнд мэдээлэл буруу ташаа биш, эсвэл таны хүүхдийн хувийн нууц, бусад эрхийг зөрчөөгүй нь тогтоогдвол сургуулийн дүүрэг танд тухайн мэдээлэлтэй холбоотой тайлбар хийх эсвэл шийдвэртэй санал нийлэхгүй байгаа шалтгаанаа тайлбарлах эрхтэйг мэдэгдэх ёстой. Энэ мэдэгдлийг танай хүүхдийн харьяалагддаг сургуулийн дүүргийн бүртгэлд оруулах ёстой.

Хүүхдийн бүртгэлд оруулсан ийм тайлбарт дараахыг заавал багтаана:

1. Сургуулийн дүүрэг нь бүртгэлийг эсвэл маргаантай хэсгийг хадгалж байгаа бүхий л хугацааны турш тайлбарыг тухайн сургуулийн дүүрэг бүртгэлийн бүрдэл хэсгээр хадгалах; **МОН**

2. Хэрэв сургуулийн дүүрэг таны хүүхдийн бүртгэлийг эсвэл маргаантай хэсгийг аль нэг этгээдэд дамжуулбал тайлбарыг мөн тухайн этгээдэд мэдэгдэх ёстой.

Хувь хүний таних мэдээллийг ил тод мэдээлэх зөвшөөрөл

Та хүүхдийг таних хувийн мэдээллийг бусдад дамжуулахыг зөвшөөрөх эрхтэй. Таны зөвшөөрөл зарим нөхцөлд шаардлагагүй байж болно.

Тухайн мэдээлэл нь боловсролын бүртгэлд багтсан бөгөөд мөн Гэр бүлийн боловсролын эрх зүй, хувийн нууцын тухай хууль (FERPA)-ийн дагуу эцэг эх зөвшөөрөл өгснөөс бусад тохиолдолд хүүхдийн боловсролын харилцаанд шууд оролцогч байгууллагуудын албан тушаалтнуудаас өөр бусад талуудад мэдээллийг дамжуулахаас өмнө таны зөвшөөрлийг заавал авах ёстой. Доор заасан нөхцөлүүдээс бусад тохиолдолд хувь хүнийг таниулах боломжтой мэдээллийг оролцогч байгууллагуудын албан тушаалтнуудад IDEA хуулийн шаардлагыг хангах зорилгоор танилцуулах үед таны зөвшөөрлийг шаардахгүй.

Шилжилтийн үйлчилгээ үзүүлж буй эсвэл тухайн үйлчилгээний зардлыг хариуцаж буй оролцогч байгууллагуудын албан тушаалтнуудад хувь хүнийг таниулах боломжтой мэдээллийг шилжүүлэхээс өмнө таны зөвшөөрлийг, эсвэл Виржиниа мужийн хуулиар насанд хүрсэн хүүхдийн зөвшөөрлийг заавал авах ёстой.

Хэрэв та хүүхдээ өөрийн амьдарч буй сургуулийн дүүргээс өөр дүүрэгт харьяалагдах хувийн сургуульд өөрийн шийдвэрээр оруулсан тохиолдолд, таны хүүхдийн хувийн мэдээллийг тухайн хувийн сургууль байрлах сургуулийн дүүргийн албан тушаалтнууд болон таны оршин суугаа сургуулийн дүүргийн албан тушаалтнуудын хооронд солилцохын өмнө таны зөвшөөрлийг авах ёстой.

ХАМГААЛАЛТ

Танай сургуулийн дүүрэг танай хүүхдийн боловсролын бүртгэлийг нууцлах үүрэгтэй.

Сургуулийн дүүрэг бүр хувийн танигдахуйц мэдээллийн нууцлалыг цуглуулах, хадгалах, задруулах болон устгах үе шатуудад хамгаалах үүрэгтэй.

Сургуулийн дүүрэг бүрд нэг албан тушаалтан хувийн танигдахуйц мэдээллийн нууцлалыг хангах үүргийг хариуцах ёстой.

Хувийн танигдахуйц мэдээллийг цуглуулж буй болон ашиглаж буй бүх хүмүүс IDEA (Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын тухай хууль) болон Гэр бүлийн боловсролын эрх ба нууцлалын тухай хууль (FERPA)-ийн хүрээнд Виржиниагийн бодлого, журамтай холбоотой сургалт, зааварчилгаа авах ёстой.

Сургуулийн дүүрэг бүр хувийн танигдахуйц мэдээлэлд нэвтрэх боломжтой агентлагуудад хамаарах хүмүүсийн нэр, албан тушаалын жагсаалтыг шинэчилж, энэ мэдээлэл нь шаардлагатай үед олон нийгэд нээлттэй байна.

Мэдээлэл УСТГАХ

Таны хүүхдийн боловсролын бүртгэл шаардлагагүй болсон гэж үзвэл та сургуулийн дүүргээс тухайн мэдээллийг устгахыг шаардах эрхтэй.

Таны хүүхдэд боловсролын үйлчилгээ үзүүлэхийн тулд цуглуулсан, хадгалсан, эсвэл ашигласан хувийн танигдахуйц мэдээлэл шаардлагагүй болсон үед таны сургуулийн дүүрэг танд мэдэгдэх ёстой.

Мэдээллийг таны хүсэлтээр устгах ёстой. Харин таны хүүхдийн нэр, хаяг, утасны дугаар, дүн, ирцийн бүртгэл, суралцсан хичээлүүд, төгссөн анги, төгссөн он зэрэг байнгын бүртгэлийг цаг хугацааны хязгаарлалтгүйгээр хадгалах боломжтой.

МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ХУВИЛБАРУУД

Журамтай холбоотой нэмэлт мэдээлэл, мөн зуучлал, гомдол шийдвэрлэлт, эрхзүйн процессын тогтолцооны тухай дэлгэрэнгүйг дараах хуудаснаас үзэх буюу VDOE-тэй холбоо барина уу: <https://www.doe.virginia.gov/?navid=652>.

ЗУУЧЛАЛ

Та санал зөрөлдөөнийг, түүний дотор эрхзүйн үйл явцын сонголт хийх хүсэлт гаргахад хүргэсэн асуудлуудыг шийдвэрлэхэд зуучлал хүсэх эрхтэй. Та болон сургуулийн дүүрэг зуучлалаас татгалзах эрхтэй. Таны гаргасан зуучлал авах хүсэлт зохих үйл явцын хүсэлтийг тань удаашруулах юм уу зогсоох шалтгаан болохгүй.

Ерөнхий мэдээлэл

Сургуулийн дүүрэг IDEA-ийн хүрээнд үүссэн аливаа асуудлыг, тэр дундаа эрхзүйн процессын хүсэлт гаргах асуудлыг өмнө үүссэн асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор зуучлалыг ашиглах боломжийг танд болон сургуулийн дүүрэгт олгох ёстой. Тиймээс та эрхзүйн процессын хүсэлт гаргасан эсэхээс үл хамааран *Эрхзүйн процессын Хүсэлт гаргах* хэсэгт заасанчлан IDEA-ийн хүрээнд үүссэн аливаа асуудлыг зуучлалаар шийдвэрлэх боломжтой.

Шаардлага

Зуучлалын үйл явц нь:

1. таны болон сургуулийн дүүргийн талын сайн дурын үндсэн дээр явагдах ёстой;
2. таны эрхзүйн процессоор сонголын эрхийг үгүйсгэх юм уу удаашруулах, эсвэл IDEA-ийн хүрээнд танд олгогдсон бусад эрхийг үгүйсгэхэд ашиглагдах ёсгүй; **мөн**
3. үр дүнтэй зуучлалын аргуудыг эзэмшсэн, мэргэжлийн болон хараат бус зуучлагчаар гүйцэтгүүлнэ.

Эцэг эхчүүдэд зуучлалын ашиг тусыг ойлгохын тулд сургуулийн дүүргээс зуучлалын үйл явцыг ашиглахаас татгалзсан эцэг эх, сургуулиудад зориулж таны тохиромжтой цаг, байршилд дараах шаардлага хангасан маргаанд үл оролцогч талтай уулзах боломжийг олгох журам боловсруулж болно. Үүнд:

1. Холбогдох маргаан шийдвэрлэх байгууллагатай гэрээтэй, эсвэл Виржиниагийн эцэг эхийн сургалт, мэдээллийн төв эсвэл олон нийтийн эцэг эхийн мэдээллийн төвүүд; **МОН**
2. Тухайн хүн танд зуучлалын ашиг тусыг тайлбарлаж, зуучлалын үйл явцыг ашиглахыг дэмжих мэдээлэл өгөх чадвартай хүн байх.

VDOE тусгай боловсрол болон холбогдох үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой хууль, журмын мэдлэгтэй, мэргэшсэн зуучлагчдын жагсаалттай байх ёстой. VDOE зуучлагчдыг ээлжлэн сонгоно.

Зуучлалын үйл явц, тэр дундаа зуучлалын хуралдааны зардлыг VDOE хариуцна.

Зуучлалын үйл явцад оролцсон уулзалтуудыг хугацаанд нь товлож, таны болон сургуулийн дүүрэгт тохиромжтой газар явуулах ёстой.

Хэрэв та болон сургуулийн дүүрэг зуучлалаар маргааныг шийдвэрлэсэн тохиолдолд, хоёр тал шийдвэрийг тусгасан хууль ёсны хүчинтэй гэрээнд гарын үсэг зурна. Гэрээ нь дараах нөхцөлтэй байна:

1. Зуучлалын явцад болсон бүх хэлэлцүүлэг нууцлалтай байх бөгөөд цаашид ямар нэгэн эрхзүйн процессын сонголт эсвэл иргэний шүүхийн ажиллагаанд нотлох баримт болгон ашиглагдахгүй байх; **МОН**
2. Та болон сургуулийн дүүргийн талын төлөөлөгчид гарын үсэг зурсан байх бөгөөд төлөөлөгч нь сургуулийн дүүргийг төлөөлөх эрхзүйн чадамжтай байх ёстой.

Бичгээр гарын үсэг зурсан зуучлалын гэрээ нь Виржиниагийн эрх бүхий шүүхэд (мужийн хуулийн дагуу ийм төрлийн хэргийг сонсох эрх бүхий шүүх) эсвэл Холбооны дүүргийн шүүхэд ашиглах эрхзүйн чадамжтай байна.

Зуучлагчийн Хараат Бус Байдал

Зуучлагч нь:

1. Таны хүүхдийн боловсрол, асрамжийн үйл ажиллагаанд оролцож буй сургуулийн дүүргийн эсвэл таны хүүхдэд шууд үйлчилгээ үзүүлж буй VDOE-ийн ажилтан байж болохгүй;
2. Зуучлагчийн бодит байдалд нөлөөлөх хувийн эсвэл мэргэжлийн ашиг сонирхолгүй байх ёстой.

Хэрэв тухайн хүн зуучлагчаар ажиллах бусад шаардлагыг хангаж байгаа бол зөвхөн мужийн агентлаг юм уу сургуулийн дүүргээс зуучлагчаар ажиллахын тулд цалин авснаар тухайн хүн сургуулийн дүүрэг эсвэл мужийн байгууллагын ажилтанд тооцогдохгүй.

МУЖИЙН ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ

ПРОЦЕССЫН СОНСГОЛ, МУЖИЙН ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ ХООРОНДЫН ЯЛГАА

Зуучлалаас гадна та сургуулийн дүүрэгтэй маргаанаа шийдвэрлэхийн тулд мужийн гомдол шийдвэрлэх үйл явц эсвэл эрхзүйн процессын сонсголыг ашиглах эрхтэй. Эдгээр аргууд нь өөр өөр журамтай. Жишээлбэл, эрхзүйн процессын сонсгол хийх хүсэлтийг зөвхөн эцэг эх юм уу сургуулийн дүүрэг гаргах боломжтой. Харин мужийн гомдол шийдвэрлэх хүсэлтийг аль ч хувь хүн, байгууллага гаргаж болно.

IDEA хуулиар мужийн гомдол шийдвэрлэх болон эрхзүйн процессын сонсголын хүсэлт гаргах үйл явцуудыг өөр өөр журмаар зохицуулдаг. Доор тайлбарласны дагуу, аливаа хувь хүн эсвэл байгууллага сургуулийн дүүрэг, VDOE, эсвэл бусад төрийн байгууллагаас IDEA-ийн шаардлагыг зөрчсөн гэж үзсэн бол мужид гомдол гаргах боломжтой. Харин хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тань тодорхойлолт, үнэлгээ, сургалтын байршилд өөрчлөлт оруулах эсвэл үнэгүй, зохистой боловсролын үйлчилгээ (FAPE) үзүүлэх асуудалтай холбоотой санал, татгалзлын асуудлаар зөвхөн та эсвэл сургуулийн дүүрэг эрхзүйн процессын сонсгол хүсэлт гаргах эрхтэй.

Хэрэв хугацааг хуулийн дагуу сунгаагүй бол VDOE-ийн ажилтнууд ерөнхийдөө 60 хуанлийн өдрийн дотор мужид гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх ёстой. Энэ баримт бичгийн *Маргаан Шийдвэрлэх Үйл Явц* хэсэгт заасанчлан хараат бус сонсголын ажилтан (шийдвэрлэх уулзалт эсвэл зуучлалаар шийдвэрлэхгүй бол) эрхзүйн процессын сонсгол явуулах хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх хугацаа дууссанаас хойш 45 хоногийн дотор бичгээр шийдвэр гаргах ёстой. Сонсголын ажилтан таны эсвэл сургуулийн дүүргийн хүсэлтээр уг хугацааг тодорхой хэмжээгээр сунгах боломжтой.

VDOE-ийн өргөдөл шийдвэрлэх журмыг авч ашиглах

Ерөнхий

VDOE нь дараах журмуудыг бичгээр гаргах ёстой:

- Аливаа гомдол, түүний дотор өөр мужаас байгууллага, хувь хүнээс гаргасан гомдлыг шийдвэрлэх;
- VDOE -д гомдол гаргах;
- VDOE-ийн гомдол гаргах журам, мэдээллийг эцэг эх болон бусад сонирхсон хүмүүс, үүнд эцэг эхийн сургалт, мэдээллийн төвүүд, хамгаалалт, өмгөөллийн байгууллагууд, бие даан амьдрах төвүүд болон бусад холбогдох байгууллагуудад өргөн хүрээтэй тараах.

VDOE-ийн гомдол шийдвэрлэх журам дараах хаягаар авах боломжтой:

<https://www.doe.virginia.gov/?navid=248>

Зохих үйлчилгээг үзүүлэхээс татгалзсан тохиолдолд авах арга хэмжээ

VDOE-н зүгээс зохих үйлчилгээ үзүүлээгүй байгааг олж тогтоосон мужийн түвшний

гомдлыг хянан шийдвэрлэхдээ дараах зүйлийг шийдвэрлэх ёстой:

1. Хүүхдийн хэрэгцээг шийдвэрлэхэд тохирсон залруулах арга хэмжээ авах зэргээр зохих үйлчилгээ үзүүлэхгүй байгаа асуудал; **мөн**
2. Хөгжлийн бэрхшээлтэй бүх хүүхдэд тохирсон үйлчилгээ үзүүлэх заалтууд.

VDOE Гомдол шийдвэрлэх журамд тавигдах үндсэн шаардлага

Цагийн хязгаар; Үндсэн Процедур

VDOE нь гомдол гаргасны дараа 60 хуанлийн өдрийн дотор дараах журмыг мөрдөх ёстой:

Үүнд:

1. Хэрэв VDOE шалгалт шаардлагатай гэж үзвэл, газар дээр нь бие даасан мөрдөн шалгалтыг явуулах;
2. Гомдол гаргагчид гомдлын талаар нэмэлт мэдээлэл аман болон бичсэн хэлбэрээр гаргах боломж олгох;
3. Сургуулийн дүүрэгт гомдолд хариу өгөх боломжийг олгох, үүнд хамгийн багадаа: (а) сургуулийн дүүргээс дэвшүүлж буй гомдлыг шийдвэрлэх санал гаргах; **болон** (б) гомдол гаргасан эцэг эх болон агентлаг хооронд тохирч зуучлал хийхэд сайн дураар оролцох боломж олгох;
4. Хамааралтай бүх мэдээллийг хянаж, сургуулийн хэлтэс IDEA-гийн шаардлагыг зөрчсөн эсэх талаар бие даасан шийдвэр гаргах; **болон**
5. Гомдол гаргагчид бичгээр хариу өгөх, үүнд гомдлын зүйл тус бүрийг шийдвэрлэх ба: (а) баримт, дүгнэлт; мөн (б) VDOE-ийн эцсийн шийдвэр гаргасан үндэслэл шалтгааныг тайлбарласан байх.

Хугацаа сунгалт; Эцсийн шийдвэр; Хэрэгжүүлэлт

Дээр дурдсан VDOE-ийн журмуудад мөн дараахыг багтаасан байх ёстой:

1. Зөвхөн дараах тохиолдолд 60 хуанлийн өдрийн хугацаа сунгалт зөвшөөрнө: (а) тухайн мужийн гомдолтой холбоотой онцгой нөхцөл байдал үүссэн үед; эсвэл (б) эцэг эх болон сургуулийн дүүрэг зуучлал эсвэл маргааныг шийдвэрлэх өөр аргаар асуудлыг шийдвэрлэхийн тулд хугацаа сунгахаар сайн дураар зөвшөөрсөн үед.
2. VDOE-ийн эцсийн шийдвэрийг үр дүнтэй хэрэгжүүлэх журамтай байх, хэрэв шаардлагатай бол үүнд: (а) техникийн туслалцааны үйл ажиллагаа; (б) хэлэлцээр; болон (в) шаардлага хангахын тулд залруулах арга хэмжээ авах гэх мэт.

Мужийн гомдол ба эрхзүйн процессын сонсгол

Хэрэв мужид бичгээр ирүүлсэн гомдол нь доорх "Эрхзүйн процессын сонсгол хийх хүсэлт гаргах" дүрмийн дагуу эрхзүйн процессын сонсгол хийх боломжтой, эсвэл мужид ирсэн гомдолд хэд хэдэн асуудал багтсан, эдгээрийн нэг буюу түүнээс дээш хэсэгт нь сонсголд хамаарахаар байгаа бол VDOE нь мужид ирсэн гомдлыг эсвэл эрхзүйн процессын сонсголоор хэлэлцэж буй асуудалд хамаарах хэсгийг сонсгол дуусах хүртэл түр хойшлуулна. Эрхзүйн процессын сонсголын нэг хэсэг биш мужид ирсэн гомдолд дурдсан аливаа асуудлыг дээр дурдсан хугацаа ба журмын хүрээнд шийдвэрлэх ёстой.

Хэрэв мужид ирсэн гомдолд хөндсөн аливаа асуудал өмнө нь явуулсан эрхзүйн процессын

сонсголоор шийдэгдсэн бөгөөд оролцогч талууд адил (та болон сургуулийн дүүрэг хооронд) бол тухайн асуудлаар гарсан эрхзүйн процессын сонсголын шийдвэр эцсийн байх бөгөөд VDOE нь гомдол гаргагчид шийдвэр эцсийн болох тухай мэдэгдэх ёстой.

VDOE нь аливаа сургуулийн дүүрэг эрхзүйн процессын сонсголыг хэрэгжүүлэхгүй байгаа талаар гаргасан аливаа гомдлыг шийдвэрлэх ёстой.

ГОМДОЛ ГАРГАХ

Та VDOE-д гомдол гаргах эрхтэй боловч таны гомдолд тодорхой асуудлыг тусгасан байх ёстой.

Байгууллага эсвэл хувь хүн дээр дурдсан журмын дагуу мужид гомдлыг бичгээр гаргах бөгөөд үүнд гарын үсэг зурсан байх. Мужид гаргах гомдолд дараах зүйлсийг агуулсан байх ёстой:

1. Сургуулийн дүүрэг IDEA хууль болон хуулийн заалтуудыг зөрчсөн тухай мэдэгдэл;
2. Гомдол гаргаж буй үндэслэсэн, баримтууд;
3. Гомдол гаргагчийн гарын үсэг болон холбоо барих мэдээлэл; мөн
4. Хэрэв тухайн гомдол нь тодорхой хүүхэдтэй холбогдох зөрчлийн тухай байгаа бол:
 - (a) Хүүхдийн нэр болон хүүхдийн оршин суугаа газрын хаяг;
 - (b) Хүүхэд сурч буй сургуулийн нэр;
 - (c) Орон гэргүй хүүхэд эсвэл залуучуудын хувьд, боломжтой холбоо барих мэдээлэл болон хүүхэд сурч буй сургуулийн нэр;
 - (d) Хүүхэдтэй холбогдох асуудлын мөн чанарын тайлбар, үүнд асуудалтай холбоотой баримтууд;
 - (e) Гомдол гаргагч талд ирүүлсэн, гомдол гаргах үед боломжтой байгаа тухайн асуудлыг шийдвэрлэх санал.

Мужийн Өргөдөл Шийдвэрлэх Журмыг Авч Ашиглах тухай хэсэгт дурдсанчлан, гаргаж буй гомдолд нь гомдол хүлээн авахаас өмнөх нэг жилийн дотор гарсан зөрчлийн талаар байх ёстой.

Мужид гомдол гаргаж буй тал нь гомдлыг VDOE-д гаргах тухайн үед хүүхдэд үйлчилж буй сургуулийн дүүрэгт гомдлын хуулбарыг хүргүүлэх ёстой.

Виржиниа мужид гомдол гаргасан талууд (та болон сургуулийн дүүргийн аль аль нь) гомдлын мөрөөр эцсийн шийдвэр гарсан өдрөөс хойш 30 хуанлийн өдрийн дотор шийдвэрийг давж заалдах эрхтэй. Гомдлыг Давж Заалдсан Хэргийг Хянагчийн шийдвэр нь эцсийнх байна. Энэхүү давж заалдах үйл явцын талаар нэмэлт мэдээллийг VDOE-ийн дээр дурдсан вэб сайтаас эсвэл VDOE-той холбогдож авах боломжтой.

ЭРХЗҮЙН ПРОЦЕССЫН ЖУРАМ

ЭРХЗҮЙН ПРОЦЕССЫН СОНСГОЛ ЯВУУЛАХ ХҮСЭЛТ ГАРГАХ

Хэрэв та болон сургууль хүүхдийн боловсролын талаар санал зөрүүтэй байгаа бол эрхзүйн процессын сонсголын хүсэлт гаргах эрхтэй. Та үнэ төлбөргүй эсвэл бага өртөгтэй эрхзүйн туслалцааны талаар мэдээлэл авах эрхтэй.

Ерөнхий мэдээлэл

Та эсвэл сургуулийн хэлтэс нь таны хүүхдийн хөтөлбөрт хамрагдах эрх тодорхойлолт, үнэлгээ, сургалтын хөтөлбөрт хуваарилалт зэрэг асуудлыг эхлүүлэх эсвэл өөрчлөх саналаас татгалзсан, эсвэл таны хүүхдэд үнэ төлбөргүй зохист ерөнхий боловсрол (FAPE) олгохтой холбоотой аливаа асуудлаар эрхзүйн сонсгол хийх хүсэлт гаргаж болно.

Эрхзүйн процессын сонсгол хийх хүсэлт нь та эсвэл сургуулийн дүүрэг тухайн үйлдэл гарсныг мэдсэн эсвэл мэдвэл зохих ёстой байсан цагаас хойш хоёр жилийн дотор болсон зөрчлийг агуулсан байх ёстой.

Та дараах нөхцөлүүдийн улмаас эрхзүйн процессын сонсгол хийх хүсэлт гаргаж чадаагүй бол дээрх хугацаа танд хамаарахгүй байж болно. Эдгээрт:

1. Сургуулийн дүүрэг эрхзүйн процессын сонсголд дурдсан асуудлуудыг шийдвэрлэсэн гэж худал мэдээлсэн бол; **эсвэл**
2. Сургуулийн дүүрэг нь IDEA-ийн дагуу хангах ёстой мэдээллийг танаас нууцалж байсан зэрэг болно.

Эцэг эхчүүдэд зориулсан мэдээлэл

Хэрэв та хүсэлт гаргасан бол, **эсвэл** та эсвэл сургуулийн дүүрэг эрхзүйн процессын сонсгол хийх хүсэлт гаргасан бол сургуулийн дүүрэг танд тухайн бүс нутагт байгаа үнэгүй эсвэл хямд өртөгтэй хууль эрх зүйн болон бусад холбогдох үйлчилгээг мэдээлэх ёстой. VDOE нь мужийн хэмжээнд боломжтой байгаа эдгээр үйлчилгээнүүдийг дараах вэб сайтад байршуулсан бий: <https://www.doe.virginia.gov/?navid=652>(<https://www.doe.virginia.gov/?navid=652>)

Эндээс “Эрхзүйн процессын сонсголын Баримт Бичиг”-ийн дотор “Хууль/Өмгөөллийн Бүлгүүд болон Тусгай Боловсролын Мэдээлэл” дээр дарна уу.

Виржини мужийн хуулиар эрхзүйн процессын сонсголд оролцогч талууд хуульч бус этгээдээр төлөөлүүлэх боломжийг олгодог. *Виржиа Мужийн Хууль, § 22.1-214 С.*

ЭРХЗҮЙН ПРОЦЕССЫН ХҮСЭЛТ

Эрхзүйн процессын хүсэлтэд тодорхой мэдээлэл агуулсан байх ёстой. Та хүсэлтийн нууцлалыг хадгалуулах эрхтэй. Та гаргасан хүсэлтдээ хариу авах эрхтэй.

Ерөнхий Мэдээлэл

Сонсгол хийх хүсэлт гаргахын тулд та эсвэл сургуулийн хэлтэс (эсвэл таны өмгөөлөгч эсвэл

сургуулийн дүүргийн өмгөөлөгч) нөгөө талд эрхзүйн процессын сонголт хийх хүсэлтээ хүргүүлэх ёстой. Энэхүү эрхзүйн процессын сонголт хийх хүсэлт нь доор дурдсан бүх агуулгыг багтаасан байх бөгөөд нууц байна. Эрхзүйн процессын сонголт хийх хүсэлт гаргасан тал нь VDOE-д уг хүсэлтийн хуулбарыг мөн хүргүүлэх ёстой.

Хүсэлтийн Агуулга

Эрхзүйн процессын хүсэлтэд дараах зүйлсийг багтаасан байх ёстой:

1. Хүүхдийн нэр;
2. Хүүхдийн оршин суугаа газрын хаяг;
3. Хүүхдийн сурч буй сургуулийн нэр;
4. Хэрэв хүүхэд орон гэргүй бол хүүхдийн холбоо барих мэдээлэл болон сурч буй сургуулийн нэр;
5. Тухайн санал болгосон эсвэл татгалзсан үйлдэлтэй холбоотой хүүхдийн асуудлын мөн чанарын тайлбар, үүнд асуудалтай холбоотой баримтууд; **МӨН**
6. Танд болон сургуулийн дүүрэгт тухайн үед мэдэгдэж, боломжтой байсан асуудлыг шийдвэрлэх санал.

Та юм уу танай сургуулийн дүүрэг (эсвэл таны өмгөөлөгч юм уу сургуулийн дүүргийн өмгөөлөгч) дээрх мэдээллийг багтаасан эрхзүйн процессын хүсэлт гаргаагүй нөхцөлд эрхзүйн процессын сонголт явуулах боломжгүй.

Эрхзүйн процессын сонголт хийх хүсэлтийг хангалттай гэж үзэх

Эрхзүйн процессын сонголын хүсэлтийг үргэлжлүүлэхийн тулд хүсэлтийг хангалттай гэж үзэх ёстой. Хүсэлтийг хүлээн авагч тал нь (та юм уу эсвэл сургуулийн дүүрэг) тухайн хүсэлтийг хүлээж авсан өдрөөс хойш 15 хуанлийн өдрийн дотор сонголт хариуцсан албан хаагчид болон нөгөө талд эрхзүйн процессын хүсэлт нь дээр жагсаасан шаардлагыг хангахгүй байгаа тухай бичгээр мэдэгдсэнээс бусад нөхцөлд эрхзүйн процессын сонголт хийх хүсэлтийг хүчинтэйд (дээрх шаардлагад нийцсэн) тооцно.

Хүлээн авагч талын хүсэлтийг хангалтгүй гэж үзсэн талаар мэдэгдэл хүлээн авснаас хойш 5 хуанлийн өдрийн дотор сонголын албан хаагч хүсэлт нь дээр дурдсан шаардлагыг хангаж байгаа эсэхийг шийдвэрлэж, танд болон сургуулийн дүүрэгт бичгээр даруй мэдэгдэх ёстой.

Хүсэлтэд өөрчлөлт оруулах

Зөвхөн дараах нөхцөлд та эсвэл сургуулийн дүүрэг нь эрхзүйн процессын сонголын хүсэлтэд өөрчлөлт оруулж болно:

1. Нөгөө тал өөрчлөлтийг бичгээр зөвшөөрч, доор дурдсанчлан асуудлыг шийдвэрлэх хуралдаанаар эрхзүйн процессын хүсэлтийг шийдвэрлэх боломжтой гэж үзсэн; **эсвэл**
2. Эрхзүйн процессын сонголт эхлэхээс дор хаяж 5 хоногийн өмнө сонголын албан хаагч өөрчлөлт оруулах зөвшөөрөл олгосон.

Хэрэв хүсэлт гаргагч тал (та эсвэл сургуулийн дүүрэг) эрхзүйн процессын сонголын хүсэлтэд өөрчлөлт оруулсан бол, шийдвэрлэх хуралдааны (хүсэлт хүлээн авснаас хойш 15 хуанлийн өдрийн дотор) болон асуудлыг шийдвэрлэх (хүсэлт хүлээн авснаас хойш 30 хуанлийн өдрийн дотор) хугацааг тус тус дахин тооцож эхэлнэ.

Сургуулийн дүүргээс эрхзүйн процессын сонголын хүсэлтэд өгөх хариу

Хэрэв сургуулийн хэлтэс танд таны эрхзүйн процессын сонголын хүсэлтэд тусгасан асуудлаар *Урьдчилан Бичгээр Мэдэгдэл* хэсэгт заасны дагуу урьдчилан бичгээр мэдэгдэл

илгээгээгүй байсан бол, сургуулийн дүүрэг эрхзүйн процессын сонсголын хүсэлт хүлээн авснаас хойш 10 хуанлийн өдрийн дотор танд дараах хариуг илгээх ёстой:

1. Сургуулийн дүүрэг нь яагаад хүсэлтэд дурдсан асуудлын мөрөөр арга хэмжээ авахыг санал болгосон эсвэл татгалзсан талаар тайлбар;
2. Таны хүүхдийн Ганцаарчилсан Боловсролын Хөтөлбөр (IEP) багийн харгалзаж үзсэн бусад сонголтууд болон яагаад тэдгээрийг хүлээн зөвшөөрөөгүй шалтгаан;
3. Сургуулийн дүүрэг тодорхой үйлдлийг санал болгох эсвэл татгалзах шийдвэртээ үндэс болгосон үнэлгээний арга, үнэлгээ, баримт бичиг, тайлангийн тайлбар; **МОН**
4. Сургуулийн дүүргээс санал болгосон эсвэл татгалзсан үйлдэлтэй холбоотой бусад хүчин зүйлсийн тайлбар.

Дээр дурдсан 1-4 зүйлд багтсан мэдээллийг ирүүлсэн нь тухайн сургуулийн дүүрэг таны эрхзүйн процессын сонсгол хийх хүсэлт хангалтгүй гэж үзэхэд саад болохгүй.

Бусад Талаас Эрхзүйн Процессын Сонсголын Хүсэлтэд Хариу Өгөх

Дээрх *Сургуулийн дүүргээс эрхзүйн процессын сонсголын хүсэлтэд өгөх хариу*” хэсэгт зааснаас бусад тохиолдолд, эрхзүйн процессын сонсголын хүсэлтийг хүлээн авагч тал хүсэлтийг хүлээн авснаас хойш 10 хуанлийн өдрийн дотор нөгөө талд хүсэлтэд багтсан асуудал тус бүрээр тодорхой хариулт өгөх ёстой.

ЖИШИГ МАЯГТУУД

Та Эрхзүйн процессын сонсгол хүсэхэд тань туслах жишиг маягт ашиглах эрхтэй.

VDOE нь эрхзүйн процессын сонсгол болон мужид гомдол гаргахад тань туслах жишиг маягтуудыг боловсруулах ёстой. Гэсэн хэдий ч VDOE эсвэл сургуулийн дүүрэг нь эдгээр загвар маягтыг ашиглахыг танаас шаардахгүй байж болно. Тиймээс таны хүсэлт нь эрхзүйн процессын сонсгол юм уу мужид өргөдөл гаргахад шаардлагатай мэдээллийг багтааж байгаа нөхцөлд энэ жишиг маягтыг эсвэл өөр бусад зохих загвар маягтыг ашиглаж болно. VDOE-ийн жишиг маягтыг үзэх: <https://www.doe.virginia.gov/?navid=652>

ЭРХЗҮЙН ПРОЦЕССЫН СОНСГОЛ ХҮЛЭЭГДЭЖ БАЙХ ҮЕД ХҮҮХДИЙГ ХӨТӨЛБӨРТ ХУВААРИЛАХ

Онцгой нөхцөл байдлаас бусад тохиолдолд эрхзүйн процесс хангагдах хүртэл таны хүүхэд та болон сургуулийн дүүрэг хооронд өөр тохиролцоо хийгээгүйгээс бусад нөхцөлд боловсролын адил үйлчилгээг үргэлжлүүлэн авах эрхтэй.

Доорх *Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сахилга батын хариуцлага тооцоход баримтлах журам* хэсэгт зааснаас бусад тохиолдолд, эрхзүйн процессын сонсголын хүсэлт нөгөө талд хүргэгдсэний дараа, шийдвэрлэх процессын хугацаанд болон аливаа хараат бус эрхзүйн процессын эсвэл шүүхийн шийдвэрийг хүлээж байх хугацаанд, хэрэв та болон VDOE эсвэл сургуулийн дүүрэг хооронд өөрөөр зөвшилцөөгүй бол таны хүүхэд одоогийн сургалтын

хөтөлбөртөө хэвээр байх ёстой.

Хэрэв эрхзүйн процессын сонсголын хүсэлтэд улсын сургуульд анх удаа элсэн орохтой холбоотой хүсэлт байгаа бол, эдгээр бүх үйл явц дуусах хүртэл таны хүүхдийг таны зөвшөөрлийн дагуу ердийн улсын сургуульд суралцуулна.

Хэрэв эрхзүйн процессын сонсголын хүсэлтэд IDEA-ийн В Хэсгийн дагуу анхны үйлчилгээ авах хүсэлттэй холбоотой бөгөөд хүүхэд IDEA-ийн С Хэсгийн үйлчилгээнээс В Хэсгийн үйлчилгээнд шилжиж байгаа, мөн хүүхэд гурван нас хүрсэн тул С Хэсгийн үйлчилгээнд хамрагдах боломжгүй болсон бол сургуулийн дүүрэг нь хүүхдийн авч байсан С Хэсгийн үйлчилгээг үзүүлэх үүрэг хүлээхгүй.

Хэрэв хүүхэд IDEA-ийн В хэсгийн дагуу үйлчилгээ авах эрхтэй гэж тогтоогдсон бөгөөд та хүүхдээ анх удаа тусгай боловсрол болон холбогдох үйлчилгээг авахыг зөвшөөрсөн бол, үйл явцын үр дүнг хүлээж байх үед сургуулийн хэлтэс маргааны хэсэг болоогүй тусгай боловсрол болон холбогдох үйлчилгээг (та болон сургуулийн дүүрэг аль аль нь зөвшөөрсөн үйлчилгээг) үзүүлэх ёстой. IDEA-ийн С Хэсэг нь нялх болон бага насны хүүхдүүдтэй холбоотой байдаг. Виржиниа мужид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд 2-с 21 насны хооронд В Хэсгийн үйлчилгээнд хамрагдах эрхтэй.

Шийдвэрлэх үйл явц

Эрхзүйн процессын сонсгол болохоос өмнө та сургуулийн ажилтнуудтай уулзаж, эрхзүйн процессын хүсэлтэд туссан асуудлуудаа хэлэлцэж, асуудлаа шийдвэрлэхийг хичээх эрхтэй. Гэсэн хэдий ч хоёр талууд асуудал шийдвэрлэх хурал хийхгүй байх юм уу эсвэл зуучлал ашиглахаар санал нийлж болно.

Асуудал шийдвэрлэх хурал

Таны эрхзүйн процессын сонсголын хүсэлтийг хүлээн авснаас хойш 15 хуанлийн хоногийн дотор, мөн эрхзүйн процессын сонсгол эхлэхээс өмнө сургуулийн дүүргээс таныг тухайн эрхзүйн процессын хүсэлтэд тусгагдсан асуудлуудаар тодорхой мэдээлэлтэй Ганцаарчилсан Боловсролын хөтөлбөр (IEP)-ийн багийн холбогдох гишүүн эсвэл гишүүдтэй уулзалт зохион байгуулах ёстой. Уулзалтад дараах зүйлс багтана:

1. Сургуулийн дүүргийн өмнөөс шийдвэр гаргах эрхтэй сургуулийн дүүргийн төлөөлөгч оролцох;
2. Хэрэв та хуульчгүй оролцож байгаа нөхцөлд сургуулийн дүүргийг төлөөлсөн хуульч оролцох шаардлагагүй.

Уулзалтын зорилго нь таны эрхзүйн процессын сонсголын хүсэлтийн тухай болон уг хүсэлт гаргах болсон үндэслэл шалтгааныг хэлэлцэх бөгөөд ингэснээр сургуулийн дүүрэгт маргааныг шийдвэрлэх боломжийг олгох явдал юм.

Дараах тохиолдолд асуудал шийдвэрлэх уулзалт шаардлагагүй:

1. Та болон сургуулийн дүүрэг уулзалтаас татгалзахыг бичгээр зөвшөөрсөн тохиолдолд;
ЭСВЭЛ
2. Та болон сургуулийн дүүрэг доорх **Зуучлал** хэсэгт заасны дагуу зуучлалын үйл явцыг ашиглахаар зөвшөөрсөн бол.

Шийдвэрлэх хугацаа

Сургуулийн дүүрэг таны эрхзүйн процессын сонсголын хүсэлтийг хүлээж авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор (асуудал шийдвэрлэх процессын үйл явцын үед) таны хүсэлд нийцүүлэн шийдвэрлээгүй бол эрхзүйн процессын сонсголыг эхлүүлэх боломжтой.

Асуудал шийдвэрлэх 30 хоногийн хугацаа дуусмагц эрхзүйн процессын сонсголын эцсийн шийдвэр гаргах 45 хоногийн хугацаа эхэлнэ. Доор тайлбарласан зарим нөхцөл байдлын улмаас асуудал шийдвэрлэх 30 хоногийн хугацаанд тохируулга хийж болно.

Та болон сургуулийн дүүрэг хоёр талаас асуудал шийдвэрлэх үйл явцыг хийхгүй байхаар тохирсноос бусад нөхцөлд хэрэв та асуудал шийдвэрлэх уулзалтад ирээгүй бол таныг уулзалтад оролцохоор зөвшөөрөх хүртэл асуудал шийдвэрлэх процессын болон эрхзүйн процессын сонсголын хугацааг хойшлуулна.

Хэрэв сургуулийн дүүргээс таныг асуудал шийдвэрлэх уулзалтад оролцуулахаар боломжит бүх аргыг ашиглаж, эдгээрийг баримтжуулсан боловч та уулзалтад оролцоогүй бол сургуулийн дүүрэг асуудал шийдвэрлэх 30 хоногийн хугацаа дууссаны дараа сонгол хариуцсан албан тушаалтанд таны хүсэлтийг хүчингүй болгох хүсэлт гаргаж болно. Эдгээр боломжит хүчин чармайлтуудыг баримтжуулсан бичлэгт сургуулийн дүүргээс уулзалт зохион байгуулахаар эцэг эхтэй уулзалт хийх байршил, цаг зэргийг тохирох оролдлогуудыг багтаах бөгөөд үүнд:

- Утсаар холбогдох оролдлого болон үр дүнгийн дэлгэрэнгүй тэмдэглэл;
- Танд илгээсэн захидлын хуулбар болон хүлээн авсан хариулт;
- Таны гэр эсвэл ажлын байранд очсон дэлгэрэнгүй тэмдэглэл болон тэр айлчлалын үр дүн зэрэг болно.

Хэрэв сургуулийн дүүрэг таны эрхзүйн процессын сонсголын хүсэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор асуудал шийдвэрлэх уулзалт хийгээгүй **эсвэл** уулзалтад оролцоогүй бол та сонгол хариуцсан албан хаагчаас эрхзүйн процессын сонсголын 45 хоногийн хугацааг эхлүүлэх хүсэлт гаргах боломжтой.

30 хоногийн хугацаанд өөрчлөлт оруулах

Хэрэв та болон сургуулийн дүүрэг асуудал шийдвэрлэх уулзалт хийхгүй байхаар бичгээр тохиролцсон бол эрхзүйн процессын сонсголын 45 хоногийн хугацаа дараагийн өдөр эхэлнэ.

Хэрэв зуучлал эхэлсэн эсвэл асуудал шийдвэрлэх уулзалт хийсний дараа, 30 хоногийн асуудал шийдвэрлэх хугацаа дуусахаас өмнө та болон сургуулийн дүүрэг хооронд зөвшилцөлд хүрэх боломжгүй тухай бичгээр харилцан зөвшөөрсөн бол эрхзүйн процессын сонсголын 45 хоногийн хугацаа дараагийн өдөр эхэлнэ.

Хэрэв та болон сургуулийн дүүрэг зуучлал ашиглахаар зөвшөөрвөл, 30 хоногийн асуудал шийдвэрлэх хугацааны төгсгөлд хоёр тал зөвшилцөлд хүрэх хүртэл зуучлалын үйл явцыг үргэлжлүүлэхээр бичгээр тохиролцож болно. Харин та юм уу эсвэл сургуулийн дүүргийн аль нэг тал зуучлалаас гарахаар шийдвэл 45 хоногийн эрхзүйн процессын сонсголын хугацаа дараагийн өдөр эхэлнэ.

Бичгээр тохиролцсон гэрээ

Хэрэв асуудал шийдвэрлэх уулзалтаар маргааныг эцэслэн шийдвэрлэвэл, та болон сургуулийн

дүүрэг дараах шаардлагуудыг хангах хууль ёсны хүчинтэй гэрээг байгуулах ёстой:

1. Та болон сургуулийн дүүргийг төлөөлөх эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурсан байх ёстой; **мөн**
2. Аль ч мужийн эрх бүхий шүүхэд (энэ төрлийн хэргийг хянан хэлэлцэх эрх бүхий аль нэг мужийн шүүх) эсвэл Холбооны Дүүргийн Шүүхэд хүчин төгөлдөр байна.

Гэрээг Хянах Хугацаа

Хэрэв та болон сургуулийн дүүрэг асуудал шийдвэрлэх уулзалтын үр дүнд гэрээ байгуулсан бол аль нэг тал (та эсвэл сургуулийн дүүрэг) гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш 3 ажлын өдрийн дотор гэрээнээс татгалзах боломжтой.

ХАРААТ БУС ЭРХЗҮЙН ПРОЦЕССЫН СОНСГОЛ

Та сургуулийн дүүрэгт эсвэл Виржиниа мужийн Боловсролын Яаманд ажилладаггүй, мэдлэгтэй сонсгол хариуцсан ажилтнаар эрхзүйн процессын сонсгол удирдуулах эрхтэй. Та болон сургуулийн дүүрэг эрхзүйн процессын сонсголын дүрэм, цагийн хуваарийг дагах ёстой.

Ерөнхий зүйл

Ямар нэг эрхзүйн процессын сонсгол явуулах хүсэлт гарсан нөхцөлд та болон маргаанд оролцогч сургуулийн дүүргийн аль аль нь *Эрхзүйн процессын Өргөдөл Гаргах* болон *Шийдвэрлэх Процесс* хэсгүүдэд заасны дагуу хөндлөнгийн хараат бус сонсгол явуулах боломжоор хангагдах ёстой.

Хараат бус сонсгол хариуцсан ажилтан

Сонсгол хариуцсан ажилтанд тавигдах наад захын шаардлага:

1. VDOE юм уу эсвэл сурагчийн боловсрол эсвэл асаргаа үйлчилгээтэй холбоотой сургуулийн дүүргийн ажилтан биш байх. Гэхдээ хэн нэгнийг дан ганц сонсгол хариуцсан ажилтнаар ажиллуулахын тулд цалин, төлбөр олгох нь тухайн байгууллагын ажилтан гэж үзэх үндэслэл болохгүй;
2. Сонсгол хариуцсан ажилтны сонсголд гүйцэтгэх ажил үүрэгтэй холбоотой хувийн болон ажил мэргэжлийн ашиг сонирхлын зөрчилгүй байх;
3. IDEA хуулийн заалтууд, холбооны болон муж улсын IDEA-тай холбогдох хууль тогтоомжийн мэдлэгтэй, мөн холбооны болон муж улсын шүүхүүдийн IDEA-ийн эрхзүйн тайлбаруудыг мэддэг байх; **мөн**
4. Сонсгол явуулах болон, хууль зүйн стандарт, шаардлагын дагуу зохих ёсны шийдвэр гаргаж, шийдвэрээ бичгээр үйлдэх чадвартай байх.

Сургуулийн дүүрэг тус бүр сонсгол хариуцсан ажилтнаар ажилладаг хүмүүсийн жагсаалтыг хөтлөх ёстой бөгөөд үүнд хүн тус бүрийн мэргэшлийн тухай дэлгэрэнгүйг агуулсан байвал зохино. Энэ мэдээллийг VDOE-н вэб сайтаас мөн VDOE-с лавлах боломжтой.

Эрхзүйн Процессын Сонсголын Сэдэв

Тусгай боловсролын сонсгол хариуцсан ажилтан нь хэргийг сонсохдоо аль нэг талын өмнө нь гаргасан мэдэгдэлд тусгагдаагүй асуудлуудыг тусгай нөхцөл байдалд үндэслэн хэлэлцэх

эрхтэй байдаг. Энэ нь хэрэглээнд дараах утгатай байна:

Өргөдөл гаргагч тал (та эсвэл сургуулийн дүүрэг) сонголын үеэр анхны сонголт явуулах өргөдөлд хамааралгүй шинэ асуудал нэмэлтээр оруулах давуу эрх эдлэхгүй бөгөөд зөвхөн нөгөө тал зөвшөөрсөн тохиолдолд нэмэлт асуудлыг гаргаж болох бөгөөд дараах нөхцөлүүд энэ дүрэмд хамаарахгүй байж болно:

Хэрэв нөгөө тал шинэ асуудлыг нэмэлтээр хэлэлцэхийг эсэргүүцсэн нөхцөлд санал гаргаж буй тал тусдаа эрхзүйн процессын сонголт хийх хүсэлт гаргаж тухайн нэмэлт асуудлыг тусад нь хэлэлцэнэ.

Хэрэв санал гаргагч тал нь нэмэлт баримт эсвэл асуудлууд юм уу эсрэг талын гаргасан үндэслэлд хариу болгох үүднээс сонголд нэмэлт асуудлуудыг хэлэлцүүлэх хүсэлтийг сонголт хариуцсан ажилтанд хандаж тавьсан нөхцөлд сонголт хариуцсан ажилтан нэмэлт асуудлуудыг хэлэлцэх эсэхийг өөрийн эрхийн дагуу шийдвэрлэх боломжтой.

СОНГОЛЫН ЯВУУЛАХ ЭРХ

Та эрхзүйн процессын сонголын үеэр тодорхой эрхүүдийг эдэлнэ, үүнд сонголт эхлэхээс өмнө сургуулийн зүгээс сонголд ашиглах бүх нотлох баримтыг үзэх, өөртөө хуульч эсвэл туслах хүмүүсийг авах, сонголын бичлэгийг үнэ төлбөргүй авах, мөн сонголыг олон нийтэд нээлттэй хийх эрх багтана.

Ерөнхий Мэдээлэл

Эрхзүйн процессын сонголд оролцож буй тал (сахилгын шийтгэлийн журамтай холбоотой сонголыг оролцуулаад) дараах эрхүүдтэй байна:

1. Хуульч болон/эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудлыг шийдвэрлэх тусгай мэдлэгтэй эсвэл сургалтад хамрагдсан хүмүүстэй оролцуулах, тэднээс зөвлөгөө авах;
2. Нотлох баримт гаргах болон баримтыг эсэргүүцэх, давхар нотолгоо лавлагаа шаардах, гэрчүүд оролцуулахыг шаардах;
3. Сонголт эхлэхээс наад зах нь ажлын 5 өдрийн өмнө тухайн талд мэдэгдээгүй нотлох баримтыг сонголд оруулахыг хориглохыг сонголт хариуцсан ажилтнаас шаардах;
4. Сонголын хуулбарыг бичгээр эсвэл үгчилсэн электрон бичлэгийн хэлбэрээр өөрийн сонголтоор авах; **мөн**
5. Эд мөрийн баримтууд, шийдвэрийн хуулбарыг бичгээр эсвэл электрон хэлбэрээр өөрийн сонголтоор авах.

Мэдээлэл ил тод байх нэмэлт шаардлага

Эрхзүйн процессын сонголт эхлэхээс наад зах нь ажлын 5 өдрийн өмнө та болон сургуулийн дүүрэг нь тухайн өдөр хүртэл хийгдсэн байгаа бүх үнэлгээ, мөн сонголын үеэр та болон сургуулийн дүүргийн зүгээс ашиглах үнэлгээнд тулгуурласан зөвлөмжүүдийг нөгөө талдаа ил тод мэдээлэх ёстой.

Хэрэв аль нэг тал энэ шаардлагыг биелүүлээгүй бол нөгөө талын зөвшөөрөлгүйгээр хамаарах үнэлгээ эсвэл зөвлөмжийг сонголд оруулахыг сонголт хариуцсан ажилтан хориглож болно.

Сонсголын үеийн Эцэг Эхийн Эрх

Танд дараах эрхүүдийг эдлэх боломж олгоно:

1. Хүүхдээ сонсголд оролцуулах;
2. Сонсголыг олон нийтэд нээлттэй болгох;
3. Сонсголын бичлэг, баримтууд, шийдвэрийг үнэ төлбөргүй авах.

Сонсголын шийдвэр

Таны эрхзүйн процессын хүсэлтэд тусгагдсан асуудлуудад тулгуурласан шийдвэр гаргуулах, шинэ асуудал үүссэн тохиолдолд тусдаа эрхзүйн процессын хүсэлт гаргах, мөн танай хүүхдийг тодорхойлох мэдээллийг шийдвэрийг олон нийтэд ил болгохоос өмнө устгуулах эрхтэй байна.

Таны хүүхэд төрөөс үзүүлэх ерөнхий боловсролын үнэ төлбөргүй үйлчилгээ (FAPE) авсан эсэх сонсгол хариуцсан ажилтны шийдвэр бодит үндэслэл дээр тулгуурлах ёстой. Үйл ажиллагааны доголдолтой холбоотой асуудлаар үүсэн маргаанд хэрэв тухайн үйл ажиллагааны доголдол нь дараах зөрчлийг үүсгэсэн нөхцөлд сонсголын ажилтан таны хүүхэд FAPE үйлчилгээг аваагүй гэсэн шийдвэрт хүрч болно. Үүнд:

- A. Хүүхдийн FAPE үйлчилгээ авах эрхийг зөрчсөн;
- B. Таны хүүхдийн FAPE үйлчилгээнд хамаарах шийдвэр гаргах үйл явцад оролцох боломжийг тань ноцтой хаагдуулсан; **Эсвэл**
- B. Үүний улмаас боловсролын үйлчилгээ авч чадаагүй.

Тэмдэглэл

Дээр дурдсан заалтуудын аль нь ч сонсгол хариуцсан ажилтан нь сургуулийн дүүргээс IDEA хуулийн (34 CFR §300.500–с 300.536 хүртэлх) заалттай холбоотой холбооны хуулийн журмын хамгаалалтын хэсэгт тавигдах шаардлагыг биелүүлэхийг шаардсан тушаал гаргахад хориглох нөхцөл болохгүй.

Эрхзүйн процессын сонсгол хийх хүсэлт тусад нь гаргах

IDEA хуулийн (34 CFR §300.500–с 300.536 хүртэлх) заалттай холбоотой холбооны хуулийн журмын хамгаалалтын аль нэг заалт нь таны өмнө нь гаргаад байсан эрхзүйн процессын сонсгол хийх хүсэлтэд тусгасан асуудлаас тусдаа асуудлаар тусад нь эрхзүйн процессын сонсгол явуулах хүсэлт гаргахад хориглох заалт болохгүй.

Виржиниа Мужийн Тусгай Боловсролд Зөвлөх Хороо болон олон нийтэд зориулж дүгнэлт, шийдвэрийг түгээх

VDOE нь хувь хүний таних аливаа мэдээллийг устгах үүрэгтэй. Түүнчлэн:

1. Эрхзүйн процессын сонсголоос гарсан шийдвэр, дүгнэлтүүдийг Мужийн Тусгай Боловсролын Зөвлөх Хороонд өгөх; **мөн**
2. Эдгээр дүгнэлт, шийдвэрийг олон нийтэд нээлттэй нийтлэх.

VDOE эдгээр үүргээ биелүүлэхийн тулд тухайн шийдвэрүүдийг улирал тутам вэб хуудсандаа байршуулна.

ШИЙДВЭР ГАРГАХ ХУГАЦАА, ХУРАЛДААНЫ ТОХИРОМЖТОЙ БАЙДАЛ БА ХЯНАЛТ

Та өөрт тохиромжтой цаг, байршилд хуралдаанд оролцох, хуралдааны эцсийн шийдвэрийг тогтоосон хугацаанд гаргуулах, шийдвэрийн хувийг гаргуулж авах эрхтэй.

Виржиниа Мужийн Боловсролын Яам (VDOE) -с 30 хоногийн асуудал шийдвэрлэх хугацаа дуусгавар болсноос хойш хуанлийн 45 хоногоос ихгүй хугацаанд **эсвэл 30 Хоногийн Асуудал Шийдвэрлэх Хугацаанд Өөрчлөлт Оруулах** хэсэгт заасны дагуу өөрчлөлт оруулсан хугацаа дуусгавар болсноос хойш хуанлийн 45 хоногоос ихгүй хугацаанд:

1. Сонсголоос эцсийн шийдвэр гарсан байх; мөн
2. Шийдвэрийн хуулбарыг оролцогч талуудад шуудангаар илгээсэн байх зэрэг шаардлагад хяналт тавьж ажиллана.

Сонсгол хариуцсан ажилтан дээр дурдсан 45 хоногийн хугацааг аль нэг талын хүсэлтээр сунгах боломжтой. Улмаар Виржиниа мужийн хуульд хугацаа сунгалт нь зөвхөн хүүхдийн эрх ашигт нийцэж байгаа тохиолдолд үүнийг зөвшөөрч болохоор заажээ.

Сонсголыг таны болон таны хүүхдийн хувьд боломжийн тохиромжтой цаг, байршилд зохион байгуулах ёстой.

ИРГЭНИЙ ХЭРГИЙН НЭХЭМЖЛЭЛ, НЭХЭМЖЛЭЛ ГАРГАХ ХУГАЦАА

Хэрэв та эсвэл сургуулийн дүүрэг сонсголын шийдвэртэй санал нийлэхгүй бол мужийн юм уу холбооны шүүхэд иргэний хэрэг үүсгэж болох ба тодорхой хугацааны шаардлагатай.

Ерөнхий зүйл

Эрхзүйн процессын сонсголын (сахилгын шийтгэлийн журмын холбогдолтой сонсгол орно) дүгнэлт, шийдвэртэй аль нэг тал (та юм уу сургуулийн дүүрэг) санал нийлэхгүй бол, уг сонсголоор авч хэлэлцсэн асуудлын мөрөөр иргэний хэрэг үүсгэх эрхтэй. Иргэний хэргийг Виржиниа мужийн эрх бүхий шүүх (энэ төрлийн хэргийг хянан шийдэх эрхтэй мужийн аль нэг шүүх) эсвэл маргааны цар хүрээнээс үл хамааран Холбооны дүүргийн шүүхэд нэхэмжилж болно.

Хугацааны хязгаарлалт

Иргэний нэхэмжлэл гаргагч тал нь (та юм уу сургуулийн дүүрэг) сонсгол хариуцсан албан тушаалтны шийдвэр гарсан өдрөөс хойш Холбооны Тойргийн Шүүхэд нэхэмжлэл гаргаж байгаа бол хуанлийн 90 хоногийн дотор, мужийн тойргийн шүүхэд нэхэмжлэл гаргаж байгаа бол хуанлийн 180 хоногийн дотор иргэний хэрэг үүсгэх эрхтэй.

Нэмэлт журам

Аливаа иргэний нэхэмжлэлд шүүх дараах үйлдлүүдийг гүйцэтгэнэ:

1. Нэхэмжлэлд авагдсан баримт бичгүүдийг хүлээн авах;
2. Та эсвэл сургуулийн дүүргийн хүсэлтээр нэмэлт нотлох баримтуудыг сонсох; **МӨН**
3. Шийдвэрээ нотлох баримтуудын давамгайл байдалд тулгуурлан гаргах, шүүхээс тохиромжтой гэж үзсэн хохирол барагдуулах арга хэмжээг авна.

Холбооны Тойргийн Шүүхийн Харьяалал

Холбооны Тойргийн шүүхүүд IDEA-ийн дагуу гарсан нэхэмжлэлийг маргааны цар хүрээнээс үл хамааран шийдвэрлэх эрхтэй.

Тэмдэглэл

IDEA-ийн В хэсгийн аль нэг заалт нь АНУ-ын Үндсэн хууль, 1990 оны Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухай хууль, 1973 оны Сэргээн засах үйл ажиллагааны тухай хуулийн V гарчиг (504-р хэсэг) болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрхийг хамгаалах бусад холбооны хуулиар олгогдсон эрх, журам, арга хэмжээг хязгаарлахгүй. Гэхдээ эдгээр хуулиудын дагуу IDEA-ийн В хэсэгт олгогдсон ижил эрхзүйн хамгаалалт авахаар иргэний хэрэг үүсгэхээс өмнө нэхэмжлэгч тал нь IDEA-ийн В хэсгийн дагуу нэхэмжлэл гаргахад шаардлагатай адил хэмжээний хүчин чармайлтыг гаргаж эрхзүйн процессын сонсголоор асуудлыг шийдвэрлэхээр оролдсон байх шаардлагатай.

Энэ нь бусад хуулиар олгогдох зарим эрхзүйн хамгаалалтууд нь IDEA-ийн хүрээнд олгогдох эрхзүйн хамгаалалттай давхцаж болох ч ерөнхийдөө эдгээр бусад хуулийн дагуу эрхзүйн хамгаалалт авахын тулд та шууд шүүхэд хандахаас өмнө эхлээд IDEA-ийн хүрээнд боломжтой байгаа захиргааны аргуудыг (жишээ нь эрхзүйн процессын сонгол) ашиглах ёстойг илэрхийлж байна.

ХУУЛЬЧ, ЭРХЗҮЙН ЗАРДАЛ, ТӨЛБӨР

Шүүхээс буруутай талаар нөгөө талын хуульч/өмгөөллийн зардлыг төлүүлж болно

Ерөнхий зүйл

IDEA-ийн дагуу гаргасан аливаа хэрэг, маргаанд та ялсан тохиолдолд таны зүгээс гарсан зардлуудаас зохих өмгөөллийн зардлыг буцаан нөхөн төлүүлэхээр шүүхээс шийдэж болно.

IDEA-ийн дагуу гаргасан аливаа хэрэг, маргаанд хэрэв таны өмгөөлөгч: (а) ямар нэгэн үндэслэлгүй, зохисгүй, баримт нотолгоогүй хэргээр шүүхэд нэхэмжлэл гаргасан нь тогтоогдсон; **эсвэл** (б) маргаан нь илт үндэслэлгүй, зохисгүй, ямар ч үндэслэлгүй нь тогтоогдсон ч ч шүүхийн маргааныг үргэлжлүүлсэн бол тухайн эрхзүйн маргаанд ялсан Виржиниа Мужийн Боловсролын Яам (VDOE) эсвэл сургуулийн дүүрэгт хамаарах эрхзүйн зардлыг таны өмгөөлөгчөөс гаргуулж нөхөн төлүүлэх шийдвэрийг шүүхээс гаргах боломжтой; **эсвэл**

IDEA-ийн дагуу гаргасан аливаа хэрэг, маргаанд хэрэв таны анхны гаргасан эрхзүйн процессын сонсголын хүсэлт юм уу эсвэл хожим нь шүүхэд үүсгэсэн нэхэмжлэл нь бусдыг дарамтлах, шаардлагагүй цаг хожих, эсвэл шаардлагагүйгээр тухайн үйл явц, эрхзүйн процессын зардлыг нэмэгдүүлсэн гэх мэт зүй бус шалтгаантай байсан нь тогтоогдвол тухайн эрхзүйн маргаанд ялсан Виржиниа Мужийн Боловсролын Яам (VDOE) эсвэл сургуулийн дүүрэгт хамаарах эрхзүйн зардлыг танаас юм уу эсвэл таны өмгөөлөгчөөс гаргуулж нөхөн төлүүлэх шийдвэрийг шүүхээс гаргах боломжтой.

Зардлыг нөхөн төлүүлэх

Шүүхээс нөхөн төлүүлэх эрхзүйн зардалд хамаарах төлбөрийг дараах байдлаар олгоно:

1. Эрхзүйн нөхөн олговрыг тухайн хэрэг буюу сонсгол явагдсан орон нутагт баримталж буй эрхзүйн адил төстэй үйлчилгээнүүдийн дунджаар тооцсон ханшаар тооцно. Нөхөн олговрыг тооцоход ямар нэгэн нэмэлт урамшуулал эсвэл үржүүлэгч ашиглахыг хориглоно.
2. IDEA хуулийн хүрээнд явагдсан ямар нэгэн үйл явц, нэхэмжлэлийг шийдвэрлэх үед эрхзүйн маргааныг эцэслэх саналыг танд бичгээр хүргүүлсний дараа гарсан ажил үйлчилгээний төлбөр, холбогдох зардлуудыг дараах тохиолдлуудад нөхөн олгохгүй, төлүүлэхгүй байж болно. Эдгээрт:
 - a. Саналыг Холбооны Иргэний хэрэг хянан шийдвэрлэх Журмын 68-р зүйлд заасан хугацааны дотор, эсвэл хэрэв энэ нь эрхзүйн процессын сонсголттой холбоотой бол хуралдаан эхлэхээс хуанлийн 10 хоногоос дээш хугацааны өмнө өгсөн бол;
 - b. Саналыг 10 хоногийн дотор хүлээж аваагүй; **МӨН**
 - c. Шүүхээс эсвэл сонсгол хариуцсан албан тушаалтан тухайн нөхөн олговор нь танд санал болгож буй саналаас илүү таатай нөхцөл болохгүй гэж үзсэн бол.

Шүүхийн шийдвэр таны талд гарсан бөгөөд та санал болгосон саналыг татгалзах хангалттай үндэслэл байсан нь тогтоогдвол дээрх хязгаарлалтаас үл хамааран эрхзүйн төлбөр, холбогдох зардлыг танд нөхөн олгож болно.

3. Ганцаарчилсан Боловсролын Хөтөлбөр (IEP)-ийн аливаа хуралтай холбоотой эрхзүйн зардлыг тухайн хурал нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа юм уу эсвэл шүүхийн ажиллагааны хүрээнд болсноос бусад тохиолдолд нөхөн олгохгүй. Виржинийгийн хуулиар энэ заалт нь эрхзүйн процессын сонсголын хүсэлт гаргахаас өмнө явуулсан зуучлалыг үйлчилгээнд мөн хамаарна.

Асуудал Шийдвэрлэх Уулзалт хэсэгт тайлбарласан асуудал шийдвэрлэх уулзалт нь эрхзүйн процессын сонсгол юм уу шүүхийн ажиллагааны үр дүнд зохион байгуулагдсан уулзалт биш юм. Мөн эрхзүйн зардлыг нөхөн олгохтой холбоотой тодорхойлолтоор үүнийг мөн эрхзүйн процессын сонсгол юм уу шүүхийн ажиллагаа гэж үзэхгүй.

IDEA хуулийн дагуу хэрэв шүүх дараах нөхцөлүүдийг олж тогтоовол эрхзүйн зардлын нөхөн олговрын хэмжээг зохих хэмжээгээр бууруулна:

1. Та эсвэл таны өмгөөлөгч тухайн хэрэг, маргааны явцад маргаан эцэслэн шийдвэрлэх процессыг үндэслэлгүйгээр хойшлуулсан;
2. Өмгөөллийн хөлсний хэмжээг ижил төрлийн үйлчилгээ үзүүлдэг, ижил ур чадвар, нэр хүнд, туршлагатай өмгөөлөгчдийн тухайн орон нутагт тогтсон цагийн хөлснөөс үндэслэлгүйгээр өндөр тогтоосон;
3. Тухайн хэрэг, маргааны шинж чанартай харьцуулахад өмгөөлөгчийн зарцуулсан цаг хугацаа болон үзүүлсэн хууль зүйн үйлчилгээ хэтэрхий их байсан; **эсвэл**
4. Таныг төлөөлж буй өмгөөлөгч нь *Эрхзүйн Процессын Хүсэлт Гаргах* хэсэгт дурдсан эрхзүйн процессын хүсэлтийн мэдэгдэлд багтсан шаардлагатай мэдээллийг сургуулийн дүүрэгт хүргүүлээгүй байсан бол.

Харин хэрэв шүүх муж юм уу эсвэл сургуулийн дүүрэг нь тухайн хэрэг, маргааныг эцэслэн шийдвэрлэх процессыг үндэслэлгүйгээр хойшлуулсан, эсвэл IDEA-ийн журмын дагуу эрх зүйн хамгаалалтын зохицуулалтыг зөрчсөн гэж үзвэл нөхөн олговрыг бууруулахгүй.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДЭД САХИЛГЫН АРГА ХЭМЖЭЭ АВАХ ҮЕД БАРИМТЛАХ ЖУРАМ

Танд хүүхдийнхээ эсрэг авсан тодорхой сахилгын арга хэмжээний талаар тайлбар өгөх эрхтэй. Хэрэв таны хүүхэд сургуулийн дүрэм зөрчвөл хүүхдийн сургалтын хөтөлбөрт өөрчлөлт орж болох бөгөөд үүний тулд сургуулийн дүүрэг тодорхой алхмуудыг дагах шаардлагатай.

СУРГУУЛИЙН АЖИЛТНУУДЫН ЭРХ МЭДЭЛ

Хэрэг тус бүрээр хянаж шийдвэрлэх

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурагчдын ёс зүйн дүрмийг зөрчсөн тохиолдолд сургуулийн ажилтнууд дараах сахилгын холбогдох шаардлагуудын дагуу тухайн хүүхдийн сургалтын хөтөлбөрт хуваарилалтад өөрчлөлт оруулах нь зохистой эсэхийг шийдэхдээ асуудал тус бүрийн онцгой нөхцөл байдлыг харгалзаж үзнэ.

Ерөнхий мэдээлэл

Хөгжлийн бэрхшээлгүй хүүхдүүдэд авдаг арга хэмжээтэй адил сургуулийн ажилтнууд дараалсан **10-с дээшгүй хичээлийн өдрөөр** хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг суралцаж буй сургалтын хөтөлбөр хуваарилалтаас түр зуурын өөр боловсролын орчин, өөр орчинд шилжүүлэх, эсвэл түдгэлзүүлж болно. Мөн тухайн хичээлийн жилд өөр давтан зөрчил үйлдсэн тохиолдолд хэрэв энэ нь хүүхдийн сургалтын хөтөлбөрийн хуваарилалтад өөрчлөлт оруулахааргүй бол тухайн хүүхдийг **10 хүртэлх хичээлийн өдрөөр** дахин түдгэлзүүлж болно (доорх *“Сахилгын арга хэмжээний улмаас сургалтын хуваарилалтыг Өөрчлөх”* гэсэн хэсгээс тодорхойлолтыг үзнэ үү).

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тухайн хичээлийн жилд нийт **10 сургуулийн өдрөөр** суралцаж буй хөтөлбөр хуваарилалтаас нь шилжүүлсэн бол дараагийн давтагдах сахилгын шийтгэлийн хугацаанд (өдрүүдэд) сургуулийн дүүрэг доорх *“Үйлчилгээ”* гэсэн хэсэгт дурдсан шаардлагын дагуу үйлчилгээг үзүүлэх ёстой.

Нэмэлт эрх мэдэл

Хэрэв ёс зүйн дүрэм зөрчсөн үйлдэл нь хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй холбоогүй байсан (доорх *“Холбогдох Байдал Тогтоох”* хэсгийг үзнэ үү) бөгөөд сахилгын арга хэмжээний улмаас хөтөлбөр хуваарилалтад хийсэн өөрчлөлт дараалсан **10 хичээлийн хоногоос** илүү үргэлжлэхээр бол сургуулийн ажилтнууд тухайн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сахилгын арга хэмжээг бусад хөгжлийн бэрхшээлгүй хүүхдүүдэд тавигдах сахилгын арга хэмжээтэй адил хэмжээ, хугацаагаар хэрэгжүүлж болох бөгөөд энэ нөхцөлд сургуулиас хүүхдэд доорх *“Үйлчилгээ”* хэсэгт тайлбарласан үйлчилгээг үзүүлэх ёстой. Тухайн үйлчилгээнд тохирох түр зуурын боловсролын орчныг хүүхдийн эцэг эх оролцсон IEP баг тодорхойлно.

Үйлчилгээ

Хэрэв таны хүүхэд сургуулийн дүрэм зөрчсөн шалтгаанаар нэг хичээлийн жилд 10 хоногоос илүү хугацаагаар сургуулиас түдгэлзүүлсэн бол түүнд боловсролын үйлчилгээг үзүүлэх ёстой. Мөн таны хүүхдийн зан үйлдлийг хянаж, дахин давтагдахгүй байхаар төлөвлөгөө боловсруулж болно

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг одоо суралцаж буй хөтөлбөр хуваарилалтаас нь хассан тохиолдолд үзүүлэх үйлчилгээг түр зуурын боловсролын орчинд үзүүлж болно.

Сургуулийн дүүрэг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд **10 буюу түүнээс цөөн өдрөөр** хөтөлбөр хуваарилалтаас хасагдсан нөхцөлд үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй бөгөөд энэ заалт нь зөвхөн хэрэв тухайн сургууль үүнтэй адил шалтгаанаар хөтөлбөрөөс хасагдсан хөгжлийн бэрхшээлгүй хүүхдэд үйлчилгээ үзүүлдэг бол хамаарна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг одоо суралцаж буй хөтөлбөрөөс нь **10 хоногоос илүү** хугацаагаар хассан бол хүүхэд:

1. Ерөнхий боловсролын хичээлийн хөтөлбөрт оролцох, зарим нөхцөлд ИЕР-ийн зорилтуудаа биелүүлэх боломжтой боловсролын үйлчилгээг үргэлжлүүлэн авах; **мөн**
2. Хувийн зөн төрхийн үнэлгээ, зан төрхөд хөндлөнгөөс туслах хөтөлбөр, хялбаршуулсан хөтөлбөр зэрэг зохих хөтөлбөрт хамрагдах бөгөөд эдгээр нь дахин сахилгын зөрчлөөс сэргийлсэн, тухайн хүүхдийн зан төрхийн доголдлыг засахад чиглэсэн байна.

Хэрэв хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нэг хичээлийн жилд **10 хичээлийн өдрөөр** хөтөлбөрөөс хасагдсан **ба** энэ хасалт нь дараалсан 10 юм у түүнээс цөөн хичээлийн өдөр байгаа **бөгөөд** энэ хасалт нь тухайн хүүхдийн сургалтын хөтөлбөрт өөрчлөлт оруулахааргүй (тодорхойлолтыг дор үзнэ үү) байгаа бол сургуулийн ажилтнууд хүүхдийн багш нарын наад зах нь нэгтэй зөвшилцөн тухайн хүүхдэд ерөнхий боловсролын хичээлийн хөтөлбөрт оролцох, зарим нөхцөлд ИЕР-ийн зорилтуудаа биелүүлэх боломжтой боловсролын үйлчилгээг ямар түвшинд үзүүлэхийг тодорхойлно.

Хэрэв хасалт сургалтын хөтөлбөрийн хуваарилалтад өөрчлөлт оруулахаар байгаа бол (доорх тодорхойлолтыг үзнэ үү), хүүхдийн ИЕР баг хүүхдэд ерөнхий боловсролын хичээлийн хөтөлбөрт оролцох, зарим нөхцөлд ИЕР-ийн зорилтуудаа биелүүлэх боломжтой боловсролын үйлчилгээг тодорхойлно.

(Хөгжлийн бэрхшээлтэй) Холбогдох нөхцөлийг тодорхойлох

Хэрэв сургуулийн дүүрэг таны хүүхдийн сургалтын хөтөлбөрийн хуваарилалтыг зан төрхийн улмаас өөрчлөхөөр шийдсэн бол та болон сургуулийн ажилтнууд уулзаж хүүхдийн зан төрх нь хөгжлийн бэрхшээлтэй холбоотой эсэхийг тодорхойлох ёстой. Мөн сургуулийн дүүрэг таны хүүхдийн ИЕР-г дагаж мөрдөөгүйн улмаас зан төрхийн доголдол үүдсэн эсэхийг харгалзах ёстой.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурагчийн ёс зүйн дүрэм зөрчсөний улмаас хүүхдийн сургалтын хөтөлбөр хуваарилалтыг өөрчлөхөөр шийдвэрлэсэн өдрөөс хойш **10 хичээлийн өдрийн** дотор (дараалсан **10 хичээлийн өдөр** юм уу үүнээс цөөн өдөр хассан бөгөөд энэ нь хөтөлбөр хуваарилалтад нөлөөлөхгүй бол хамаарахгүй), сургуулийн дүүрэг, эцэг эх, болон ИЕР багийн холбогдох гишүүд (эцэг эх болон сургуулийн хэлтэс тодорхойлно) хүүхдийн хувийн хэрэг болон ИЕР, багш нарын ажиглалт, эцэг эхээс ирүүлсэн бусад мэдээллүүдийг

хянан үзэж дараахыг тодорхойлно:

1. Үүссэн сахилга батын зөрчил нь хүүхдийн хөгжлийн бэрхшээлээс үүдсэн, эсвэл хөгжлийн бэрхшээлтэй шууд хамааралтай эсэх; **ЭСВЭЛ**
2. Үүссэн сахилга батын зөрчил нь тухайн сургуулийн дүүрэг хүүхдийн IEP-г хэрэгжүүлээгүйгээс шууд хамааралтай эсэхийг тогтооно.

Хэрэв сургуулийн дүүрэг, эцэг эх, болон хүүхдийн IEP багийн холбогдох гишүүд дээрхийн аль нэг нөхцөлөөр санал нийлсэн бол уг сахилга батын зөрчил нь хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн илрэл гэж үзнэ.

Хэрэв сургуулийн дүүрэг, эцэг эх, болон хүүхдийн IEP багийн холбогдох гишүүд тухайн сахилга батын зөрчил нь сургуулийн дүүрэг хүүхдийн IEP-г хэрэгжүүлээгүйгээс шууд хамааралтайг тогтоосон нөхцөлд сургуулийн дүүрэг үүдсэн үр дагаврыг арилгах шуурхай арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

Зан төлөв нь хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн илрэл байсныг тодорхойлох

Хэрэв сургуулийн дүүрэг, эцэг эх, болон IEP багийн холбогдох гишүүд тухайн үйлдэл нь хүүхдийн хөгжлийн бэрхшээлээс үүдсэн гэж үзсэн бол IEP баг дараах алхмуудыг хийх ёстой:

1. Хэрэв сургуулийн дүүрэг өмнө нь тухайн хүүхдэд зан төрхийн байдлын үнэлгээ хийж, үүний улмаас сурагчийн хөтөлбөр хуваарилалтад өөрчлөлт оруулсан, сахилга батын зөрчилд хөндлөнгөөс туслах хөтөлбөр хэрэгжүүлж байгаагүй бол хүүхдэд зан төрхийн байдлын үнэлгээ хийнэ; **ЭСВЭЛ**
2. Хэрэв сахилга батын зөрчилд хөндлөнгөөс туслах төлөвлөгөө өмнө нь боловсруулсан бол төлөвлөгөөг хянаж, шаардлагатай бол сахилга батын зөрчлийг шийдвэрлэхэд чиглэсэн өөрчлөлт оруулах ёстой.

Доорх "Тусгай нөхцөл байдал" гэсэн дэд хэсэгт тайлбарласнаас бусад тохиолдолд хэрэв эцэг эх болон сургуулийн зүгээс сахилга батын зөрчилд хөндлөнгөөс туслах төлөвлөгөөнд оруулсан өөрчлөлтийн хүрээнд хүүхдийн одоогийн хөтөлбөр хуваарилалт нь зохистой гэж үзээгүй бол сургуулийн дүүрэг хүүхдийг хасаад байсан хөтөлбөрт нь буцаан оруулах ёстой.

Онцгой нөхцөл байдал

Хэрэв таны хүүхдийн сахилга батын асуудал хууль бус буюу хяналттай мансууруулах бодис, аюултай зэвсэг, эсвэл бусдын бие махбодод ноцтой гэмтэл учруулсан бол сургуулийн дүүрэг таны хүүхдэд сахилгын арга хэмжээ авах илүү олон сонголттой байна.

Сахилга батын доголдол нь хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн илрэл байсан эсэхээс үл хамааран дараах тохиолдлуудад сургуулийн ажилтнууд суралцагчийг сургуулийн 45 хүртэлх хоногийн хугацаанд түр зуурын аль нэг хувилбарын боловсролын орчинд (хүүхдийн IEP багаар тогтоосон) авч болно. Хэрэв хүүхэд:

- А. Сургуульд зэвсэг (доорх тодорхойлолтыг үзнэ үү) авч явах буюу сургууль, сургуулийн байранд, эсвэл VDOE буюу сургуулийн дүүргийн харьяа сургуулийн үйл ажиллагаанд зэвсэгтэй байх;
- Б. Сургууль, сургуулийн байранд, эсвэл VDOE буюу сургуулийн дүүргийн харьяа сургуулийн үйл ажиллагаанд оролцох үеэр хууль бус мансууруулах бодис санаатайгаар биедээ авч явсан эсвэл хэрэглэсэн (доорх тодорхойлолтыг үзнэ үү),

эсвэл хяналттай бодис худалдаж, борлуулсан, (доорх тодорхойлолтыг үзнэ үү);

Эсвэл

- В. Сургууль, сургуулийн байранд, эсвэл VDOE буюу сургуулийн дүүргийн харьяа сургуулийн үйл ажиллагаанд оролцох үеэр бусдын бие махбодод ноцтой гэмтэл (доорх тодорхойлолтыг үзнэ үү) учруулсан зэрэг байна.

Тодорхойлолтууд

Хяналттай бодис гэдэг нь Хяналттай Бодисын Тухай Хууль (Controlled Substances Act)-ийн (21 ДҮГЭЭР ЗҮЙЛИЙН 812(с)-ийн 202 дугаар зүйлийн (с) хэсгийн I, II, III, IV буюу V хэсгүүдэд тодорхойлогдсон мансууруулах болон бусад бодисыг хэлнэ.

Хууль бус мансууруулах бодис гэдэг нь нэгэн төрлийн хяналттай бодис юм. Гэхдээ эрх бүхий эрүүл мэндийн мэргэжлийн хүний хяналтын дор хуулийн дагуу эзэмшиж, хэрэглэж байгаа, эсвэл уг хуулиар болон Холбооны хуулийн өөр аль нэгэн заалтын дагуу хууль ёсоор эзэмшиж, хэрэглэж болдог хяналттай бодисоос бусад бодисыг хэлнэ.

Бие махбодын хүнд гэмтэл гэдэг нь “Unites States Code”-н 1365-р зүйлийн (h) дэд хэсгийн (3) дэд хэсгийн (h) дэд хэсгийн дагуу "бие махбодын хүнд гэмтэл" гэсэн нэр томъёог тодорхойлсон байдаг. Үүнд "Бие эрхтний гэмтлийн улмаас амь нас алдах эрсдэлд орох, бие махбодын хүчтэй өвдөлт, бие эрхтэнд удаан үргэлжлэх илт гажиг согог үүсэх, эсвэл биеийн аль нэг эрхтний юм уу сэтгэцийн үйл ажиллагааны чадвар удаан хугацаагаар сулрах юм уу бүр мөсөн алдагдахыг хэлнэ" гэжээ.

Зэвсэг гэдэг нь “Code of Virginia”-н 18, “United State Code”-н, § 18.2-308.1-ийн 930-р зүйлийн (g) дэд хэсгийн эхний дэд хэсгийн (g) дэд хэсгийн (2) доор өгөгдсөн "аюултай зэвсэг" гэсэн утгатай. Аюултай зэвсэг гэдэг нь зэвсэг, хэрэгсэл, багаж, материал, эсвэл бодис, амьтан эсвэл бусад арга хэрэгсэл гэх мэт үхэлд хүргэх эсвэл бие махбодод ноцтой гэмтэл учруулах, эсвэл амархан гэмтгэх боломжтой аливаа хэрэгслийг хэлэх бөгөөд энэ ойлголтод 3 инчээс богино халаасны хутгыг тооцоогүй байна.

Мэдэгдэл

Сурагчдын ёс зүйн дүрэм зөрчсөний улмаас хүүхдийн сургалтын хөтөлбөрийн хуваарилалтад өөрчлөлт оруулж хасалт хийх шийдвэр гаргасан өдөр сургуулийн дүүрэг тухайн шийдвэрийн талаар эцэг эхчүүдэд мэдэгдэж, эцэг эхчүүдэд эрхзүйн хамгаалалтын мэдэгдэл өгөх ёстой.

САХИЛГЫН УЛМААС ХАСАГДСАНААР ХӨТӨЛБӨРИЙН ХУВААРИЛАЛТ ӨӨРЧЛӨГДӨХ

Зарим тохиолдолд таны хүүхдийг сургуулиас хассаныг хөтөлбөрт “өөрчлөлт” орох гэж үздэг.

Дараах тохиолдлуудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тухайн үеийн сургалтын хөтөлбөрөөс хассаныг **хөтөлбөрт өөрчлөлт орох** гэж үзнэ. Эдгээрт:

1. Хасалт нь хичээлийн дараалсан 10 өдрөөс дээш байгаа бол; **Эсвэл**
2. Дараах шалтгаануудын улмаас тухайн хүүхэд хэд хэдэн удаа хасагдаж байсан бөгөөд энэ нь давтагдах шинжтэй болсон бол:
 - а. Хичээлийн жилд удаа дараалан хасагдсан нийт хугацаа 10-с дээш хичээлийн

- өдөр болсон;
- b. Тухайн хүүхдийн сахилга батын зөрчил өмнө нь сургуулиас удаа дараалан хасагдахад хүргэсэн тохиолдлуудтай адил төстэй байх; **МОН**
 - c. Хасагдсан тохиолдол бүрийн хугацаа, хүүхдийг хассан нийт хугацаа, хасагдсан тохиолдлуудын хоорондын зай зэрэг нэмэлт хүчин зүйлс.

Сургуулиас давтан хасагдсан байдал нь хөтөлбөрийн хуваарилалтад өөрчлөлт оруулах эсэхийг сургуулийн дүүрэг тохиолдол тус бүрээр тодорхойлох бөгөөд хэрэв шийдвэрийг эс зөвшөөрвөл эрхзүйн процессоор юм уу шүүхээр хянан шийдвэрлэнэ.

СУРГАЛТЫН ОРЧНЫГ ТОДОРХОЙЛОХ

Ганцаарчилсан Боловсролын Хөтөлбөр (IEP) баг нь сургуулиас хасагдсаны улмаас **хөтөлбөрт өөрчлөлт орсон** эсвэл **Нэмэлт арга хэмжээ** болон **Онцгой нөхцөл байдал** дэд гарчгуудад зааснаар хасагдсан сурагчийн түр алтернатив сургалтын орчныг тодорхойлох ёстой.

ДАВЖ ЗААЛДАХ

Таны хүүхдэд сахилгын арга хэмжээ авах сургуулийн дүүргийн шийдвэртэй санал нийлэхгүй бол та эрхзүйн процессын сонсгол хийх эрхтэй.

Ерөнхий мэдээлэл

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх нь дараах зүйлс дээр санал нийлэхгүй бол дээр дурдсан сонсголыг явуулах хүсэлт гаргаж болно:

1. Эдгээр сахилгын шийдвэрийн дагуу гаргасан хөтөлбөр хуваарилалтын шийдвэр; **эсвэл**
2. Дээр тайлбарласан сахилга батын нөлөөлөл тогтоосон байдал.

Хэрэв сургуулийн дүүрэг хүүхдийг одоогийн хөтөлбөрт байлгах нь тухайн хүүхдэд эсвэл бусдад гэмтэл учруулах өндөр магадлалтай гэж үзвэл тэд сонсголын хүсэлт гаргаж болно.

Сонсгол Хариуцсан Албан Хаагчийн Эрх Мэдэл

Шударга Сонсголын Албан Тушаалтан хэсэгт дурдсан шаардлагыг хангасан сонсголын албан тушаалтан эрхзүйн процессын сонсголыг явуулж шийдвэр гаргах ёстой. Сонсголын албан тушаалтан дараах шийдвэрийг гаргаж болно:

1. Хэрэв сонсголын албан тушаалтан хүүхдийг хөтөлбөрөөс хассан нь **Сургуулийн Ажилтнуудын Эрх Мэдэл** хэсэгт тайлбарласан шаардлагыг зөрчсөн гэж үзвэл, эсвэл хүүхдийн сахилга бат нь хөгжлийн бэрхшээлийнх нь илрэл байсан гэж үзсэн тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөтөлбөрт нь буцааж оруулна; **эсвэл**
2. Хэрэв сонсголын албан тушаалтан хүүхдийг одоогийн хөтөлбөрт байлгах нь тухайн хүүхдэд эсвэл бусдад гэмтэл учруулах өндөр магадлалтай гэж үзвэл хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг 45 хичээлийн өдрөөс хэтрэхгүй хугацаанд түр хувилбарт хөтөлбөрт шилжүүлэхийг тушааж болно.

Хэрэв сургуулийн дүүрэг хүүхдийг одоогийн хөтөлбөрт байлгах нь тухайн хүүхдэд эсвэл

бусдад гэмтэл учруулах өндөр магадлалтай гэж үзвэл эдгээр сонсголыг дахин явуулж болно.

Эцэг эх эсвэл сургуулийн дүүрэг ийм сонсголыг явуулах хүсэлт гаргасан тохиолдолд, **Эрхзүйн Процессын Журмын Хүсэлт, Эрхзүйн Процессын Хүсэлтээр Сонсгол явуулах** гэсэн гарчгийн дор тайлбарласан шаардлагыг хангасан сонсгол зохион байгуулагдах ёстой бөгөөд үүнд дараах нөхцөлүүд хамаарахгүй. Эдгээрт:

1. Сургуулийн хэлтэс яаралтай сонсголыг зохион байгуулах шаардлагатай ба сонсголын хүсэлт гаргаснаас хойш **20** хичээлийн өдрийн дотор сонсгол явуулж, сонсгол болсноос хойш **10** хичээлийн өдрийн дотор шийдвэр гаргахаар бол.
2. Хэрэв эцэг эх болон сургуулийн дүүрэг уулзалтаас татгалзахаар бичгээр тохирсон эсвэл зуучлал ашиглахаар тохирсон бол, эрхзүйн процессын хүсэлтийн тухай тухай мэдэгдэл хүлээн авснаас хойш **7** хоногийн дотор асуудал шийдвэрлэх хурал хийх ёстой. Хэрэв эрхзүйн процессын хүсэлтийг хүлээн авснаас хойш хуанлийн **15** хоногийн дотор талууд харилцан тохиролцоонд хүрэх шийдвэрт хүрээгүй бол сонсгол явуулж болно.

Яаралтай сонсголын шийдвэрийг бусад сонсголын шийдвэртэй ижил хэлбэрээр давж заалдах боломжтой (дээрх **Давж Заалдах** хэсгийг үзнэ үү).

ДАВЖ ЗААЛДАХ ХУГАЦААНД ХӨТӨЛБӨРТ ХУВААРИЛАХ

Дээр дурдсанчлан, эцэг эх эсвэл сургуулийн дүүрэг сахилгын асуудалтай холбоотой холбогдох сонсгол явуулах хүсэлт гаргасан тохиолдолд хүүхэд (эцэг эх болон сургуулийн хэлтэс дүүрэг өөрөөр тохиролцоогүй бол) сонсголын албан тушаалтны шийдвэр гарах хүртэл эсвэл **Сургуулийн Ажилтнуудын Эрх Мэдэл** хэсэгт тайлбарласан хөтөлбөрөөс хасах хугацаа дуусах хүртэл түр өөр хувилбарт сургалтын орчинд суралцах ёстой бөгөөд эдгээрийн аль түрүүлж тохиолдсон нөхцөлийг баримтална.

ТУСГАЙ БОЛОВСРОЛ, ХОЛБОГДОХ ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДАХ ЭРХ ҮҮСЭЭГҮЙ ХҮҮХДИЙН ХАМГААЛАЛ

Сахилгын арга хэмжээ авагдсан ч тусгай боловсрол юм уу холбогдох үйлчилгээнд хараахан хамрагдаагүй хүүхдэдээ та зарим төрлийн хамгаалалт авах эрхтэй.

Ерөнхий мэдээлэл

Хүүхдийг тусгай боловсрол болон холбогдох үйлчилгээнд хамрагдах эрхтэй гэж тодорхойлоогүй байсан ч сурагчийн ёс зүйн дүрэм зөрчсөн, гэхдээ сургуулийн дүүрэг тухайн сахилгын арга хэмжээ авахад хүргэсэн үйлдэл гарахаас өмнө хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй байсан талаар (доор тайлбарласанчлан) мэдэж байсан бол хүүхэд энэ мэдэгдэлд дурдсан хамгаалалтыг шаардах эрхтэй.

Сахилгын Асуудалтай Холбогдох өмнөх нөхцөлийн тухай мэдлэг

Хүүхэд сахилгын арга хэмжээ авахад хүргэсэн үйлдэл гарахаас өмнө, дараах тохиолдлуудад сургуулийн дүүрэг хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй болохыг мэдэж байсан гэж үзнэ:

1. Хүүхдийн эцэг эх тусгай боловсрол болон холбогдох үйлчилгээ авах шаардлагатай байгааг тухайн хүүхдийн багшид эсвэл холбогдох боловсролын байгууллагын удирдах

- ажилтанд бичгээр илэрхийлсэн;
2. Эцэг эх нь IDEA-ийн В хэсгийн дагуу тусгай боловсрол болон холбогдох үйлчилгээнд хамрагдах эрхтэй эсэхийг тодруулах үнэлгээ хийхийг хүссэн; **эсвэл**
 3. Хүүхдийн багш эсвэл сургуулийн бусад ажилтнууд хүүхдийн тодорхой зан үйлдлийн давтагдах хандлагын талаар тусгай боловсролын газрын захирал эсвэл сургуулийн дүүргийн бусад удирдах ажилтанд тодорхой асуудлыг илэрхийлж байсан.

Дээрхтэй хамаарахгүй хүчин зүйлс

Дараах тохиолдлуудад сургуулийн дүүрэг энэ талаар мэдээгүй гэж үзнэ:

1. Хүүхдийн эцэг эх үнэлгээ хийлгэхээс татгалзсан эсвэл тусгай боловсролын үйлчилгээг зөвшөөрөөгүй; **эсвэл**
2. Хүүхдийг үнэлж, IDEA-ийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд биш гэж тодорхойлсон.

Өмнөх нөхцөлийг мэдээгүй байх тохиолдолд хамаарах нөхцөлүүд

Хэрэв хүүхдэд сахилгын арга хэмжээ авахын өмнө сургуулийн дүүрэг дээр дурдсан **Сахилгын асуудалтай холбоотой өмнөх нөхцөлийн мэдлэг** болон **Онцгой нөхцөл** гэсэн хэсгүүдийн дагуу хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй болох талаар мэдлэггүй байсан бол, хүүхдэд хөгжлийн бэрхшээлгүй хүүхдүүдэд ижил төстэй үйлдэл гаргасан тохиолдолд хэрэгжүүлдэг сахилгын арга хэмжээг авч болно. Гэхдээ сахилгын арга хэмжээ авах хугацаанд хүүхдэд үнэлгээ хийх хүсэлт гаргасан бол үнэлгээг яаралтай хийх ёстой.

Үнэлгээ дуустал хүүхэд сургуулийн захиргаанаас тогтоож өгсөн сургалтын хөтөлбөртөө хэвээр байх бөгөөд үүнд ямар нэгэн боловсролын үйлчилгээгүй сургуулиас хасах эсвэл түдгэлзүүлэх шийтгэлүүд багтана.

Хэрэв хүүхэд үнэлгээний үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд гэж тодорхойлогдвол сургуулийн дүүрэг эцэг эхийн өгсөн мэдээлэл болон үнэлгээний үр дүнг харгалзан үзэж, IDEA-ийн дагуу тусгай боловсрол болон холбогдох үйлчилгээг дээр тайлбарласан сахилгын арга хэмжээний хамт үзүүлэх ёстой.

Хууль сахиулах байгууллага, шүүхэд шилжүүлэх, эдгээрээс авах арга хэмжээ

Зарим тохиолдолд цагдаагийн газар, шүүх танай хүүхдийн сургуулийн дүүргээс таны хүүхдийн талаар мэдээлэл авах боломжтой.

IDEA-ийн В хэсэг нь дараах зүйлсийг хориглохгүй:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн үйлдсэн гэмт хэргийг холбогдох байгууллагад мэдээлэхийг аливаа байгууллагад хориглохгүй; **эсвэл**
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн үйлдсэн гэмт хэрэгт хамаарах Холбооны болон Муж улсын хуулийг хэрэгжүүлэх үүргээ гүйцэтгэхэд Виржиниа мужийн хууль сахиулах болон шүүхийн байгууллагуудад хориг болохгүй.

Бичиг Баримт Дамжуулах

Хэрэв сургуулийн дүүрэг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн үйлдсэн гэмт хэргийг мэдээлсэн бол сургуулийн хэлтэс дараах үүргийг хүлээнэ:

1. Хүүхдийн тусгай боловсрол болон сахилгын баримтуудын хуулбарыг тухайн

байгууллагаас гэмт хэргийн мэдээллийг хүлээлгэн өгсөн байгууллагад хянуулахаар дамжуулах ёстой; **МӨН**

2. Хүүхдийн тусгай боловсрол болон сахилгын баримтуудын хуулбарыг зөвхөн Гэр бүлийн боловсролын эрх болон хувийн мэдээллийн нууцын тухай хууль (FERPA) хуульд заасан хэмжээнд дамжуулж болно.

ЭЦЭГ ЭХИЙН ШИЙДВЭРЭЭР ХҮҮХДИЙГ ХУВИЙН СУРГУУЛЬД ТӨСВИЙН ЗАРДЛААР СУРГАХ ҮЕД ТАВИХ ШААРДЛАГА

Ерөнхий зүйл

Та хүүхдээ хувийн сургуульд өөрсдийн шийдвэрээр сургаж байх үедээ тодорхой үйлчилгээ авах эрхтэй байж болно.

Сургуулийн дүүргээс танай хүүхдэд зориулж төрөөс үзүүлэх үнэгүй ерөнхий боловсролын үйлчилгээ (FAPE) үзүүлэх боломжийг санал болгосон ч та хүүхдээ хувийн сургууль эсвэл сургалтын байгууллагад сургахаар шийдсэн бол хувийн сургуульд сурч буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай боловсрол болон холбогдох үйлчилгээний зардлыг төлөх үүргийг IDEA хуулиар сургуулийн дүүрэг хүлээхгүй. Харин тухайн хувийн сургууль байршиж буй сургуулийн дүүрэг нь эцэг эхийн шийдвэрээр хувийн сургуульд сурч хүүхдүүдэд хамаарах IDEA хуулийн (34 CFR §§300.131 - 300.144) заалтуудын дагуу үйлчилгээнд хамрагдах буй хүүхдүүдийн жагсаалтад танай хүүхдийг багтаах ёстой.

Хувийн сургуульд сургах зардлыг нөхөн төлөх

Таны хүүхэд өмнө нь сургуулийн дүүргээс тусгай боловсрол болон холбогдох үйлчилгээг авч байсан бөгөөд та хүүхдээ тухайн сургуулийн дүүргийн зөвшөөрөл эсвэл зөвлөмжгүйгээр хувийн сургуульд (цэцэрлэг, бага сургууль эсвэл дунд сургууль) суралцуулахаар шийдсэн нөхцөлд хэрэв шүүх эсвэл сонсгол хариуцсан албан тушаалтан тухайн сургуулийн дүүрэг нь таныг хүүхдээ хувийн сургуульд оруулахаас өмнө цаг алдалгүйгээр хүүхдэд FAPE үйлчилгээг санал болгоогүйг, мөн тухайн хувийн сургуульд хүүхдээ оруулсныг зохистой байсан гэж үзвэл сургуулийн дүүргээс хүүхдийг хувийн сургуульд сургах зардлыг сургуулийн дүүргээс гаргуулж танд нөхөн төлүүлэхээр шийдвэрлэж болно. Сонсгол хариуцсан албан тушаалтан эсвэл шүүх хэдийгээр хүүхдийг хувийн сургуульд сургасан нь Виржиниа Мужийн Боловсролын Яамнаас болон сургуулийн дүүргүүдэд ашигладаг Виржиниа мужийн сурлагын стандартад нийцэхгүй байсан ч таны хувийн сургуульд хүүхдээ сургасныг зохистой гэж үзэж болно.

Нөхөн Олговрын Хязгаарлалт

Дээрх нөхөн олговрыг дараах тохиолдолд багасгах эсвэл татгалзаж болно:

1. Хэрэв: (а) Хүүхдээ улсын сургуулиас гаргахаас өмнөх сүүлийн Ганцаарчилсан Боловсролын Хөтөлбөр (IEP)-ийн хурал дээр та хүүхдэд зориулан сургуулийн дүүргээс санал болгосон FAPE-ийг хүлээн авахаас татгалзаж буйгаа, улмаар хувийн сургуульд төсвийн зардлаар суралцуулах бодолтой байгаагаа IEP багт мэдэгдээгүй; эсвэл (б) Хүүхдээ улсын сургуулиас гаргахаас 10 ажлын өдрийн (ажлын өдрүүдэд тохиох бүх баяр ёслолын өдрийг тооцно) өмнө энэ талаар сургуулийн хэлтэст бичгээр мэдэгдээгүй;
2. Хэрэв хүүхдээ улсын сургуулиас гаргахаас өмнө сургуулийн дүүрэг танд хүүхдийг үнэлэх тухай урьдчилан бичгээр мэдэгдсэн байсан бөгөөд энэ нь зохистой, боломжийн

зорилго агуулсан үнэлгээ байсан ч та хүүхдээ үнэлгээнд хамруулаагүй; **эсвэл**

3. Шүүх таны үйлдлийг зохисгүй гэж үзсэн тохиолдолд.

Харин нөхөн олговрыг дараах тохиолдлуудад бууруулах эсвэл татгалзах ёсгүй:

1. Хэрэв та дээрх мэдэгдлийг өгөөгүй бол дараах тохиолдлуудад нөхөн олговрыг бууруулах юм уу татгалзаж болохгүй: (а) Сургууль танд мэдэгдэл өгөхөд саад хийсэн; (б) Та дээр дурдсан мэдэгдэл өгөх үүрэгтэй тухай мэдэгдэл та хүлээж аваагүй байсан; эсвэл (в) Дээр дурдсан шаардлагыг дагаж мөрдсөн нөхцөлд хүүхдэд тань бие махбодын хохирол учруулах өндөр магадлалтай бол; **мөн**
2. Шүүх эсвэл сонсгол хариуцсан албан тушаалтны шийдвэрээр дараах тохиолдолд эцэг эхээс шаардсан мэдэгдэл өгөөгүй байсан ч нөхөн олговрыг багасгаж эсвэл татгалзаж болохгүй: (а) Эцэг эх нь бичиг үсэг тайлагдаагүй эсвэл англиар бичиж чадахгүй байсан; эсвэл (б) Дээр дурдсан шаардлагыг дагаж мөрдвөл хүүхдэд ноцтой сэтгэл санааны хохирол учруулах өндөр магадлалтай байсан зэрэг болно.

ТӨСВӨӨС ҮЗҮҮЛЭХ ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ ЮМ УУ ДААТГАЛ АШИГЛАХТАЙ ХОЛБООТОЙ ЭЦЭГ ЭХИЙН ЭРХИЙН МЭДЭГДЭЛ

Сургуулийн дүүрэг төсвөөс үзүүлэх халамжийн тэтгэмж юм уу даатгал ашиглахаас өмнө таны зөвшөөрлийг бичгээр авах ёстой бөгөөд төсвөөс үзүүлэх халамжийн тэтгэмж юм уу даатгал ашиглахтай холбоотой таны эрхийг жил бүр мэдэгдэх ёстой.

Орон нутгийн боловсролын агентлагууд IDEA-ийн В хэсэгт заасан үйлчилгээ үзүүлэх эсвэл үүнтэй холбоотой зардлыг төлөх зорилгоор хүүхдэд хамаарч буй Medicaid юм уу бусад төсвөөс үзүүлдэг тэтгэмж эсвэл даатгалын хөтөлбөрүүдийг тухайн байгууллагуудаас зөвшөөрсөн хэмжээнд ашиглах хүсэлт гаргаж болно. IDEA хуулиар нь хүүхдийн эсвэл эцэг эхэд хамаарах төсвөөс үзүүлдэг тэтгэмж эсвэл даатгалыг анх удаа ашиглахаас өмнө төрийн байгууллагууд эцэг эхээс нэг удаагийн зөвшөөрөл авахыг шаарддаг. Энэхүү нэг удаагийн зөвшөөрөл нь дараах зүйлсийг агуулсан байх ёстой:

1. Бусдад дамжуулж болох хувь хүнийг таних боломжтой мэдээлэл;
2. Мэдээллийг дамжуулж буй зорилго;
3. Мэдээллийг ямар байгууллагад дамжуулж болох;
4. Эцэг эх нь төрийн байгууллагаас IDEA-ийн В хэсгийн дагуу үзүүлсэн үйлчилгээний төлбөрийг төлөх зорилгоор хүүхдийн эсвэл эцэг эхэд хамаарах төсвөөс үзүүлдэг тэтгэмж эсвэл даатгалыг ашиглахыг ойлгож, зөвшөөрсөн байх ёстой.

Орон нутгийн боловсролын агентлагууд эцэг эхийн зөвшөөрлийг анх удаа авахын өмнө хүүхдийн эсвэл эцэг эхэд хамаарах төсвөөс үзүүлдэг тэтгэмж эсвэл даатгалыг ашиглах тухай бичгээр мэдэгдэх бөгөөд үүнээс хойш энэ мэдэгдлийг жил бүр эцэг эхэд бичгээр өгөх ёстой.

Эцэг эхчүүд хүүхдийнхээ хувь хүний таних мэдээллийг мужийн халамжийн тэтгэмж эсвэл даатгалын хөтөлбөрийн хариуцсан байгууллагуудад дамжуулах зөвшөөрлөө хүссэн үедээ хүчингүй болгох эрхтэй. Хувийн мэдээллийг дамжуулах зөвшөөрлөө буцаах эсвэл өгөхөөс татгалзах нь төрийн байгууллагын шаардлагатай бүх үйлчилгээг үнэ төлбөргүйгээр үзүүлэх үүрэг хариуцлагаас чөлөөлөхгүй.

Орон нутгийн боловсролын агентлагуудад дараах зүйлсийг хориглоно:

1. Эцэг эхчүүдийг хүүхдэдээ IDEA-ийн В хэсгийн дагуу төрөөс үзүүлэх үнэгүй ерөнхий боловсролын үйлчилгээ (FAPE) авахын тулд төсвөөс үзүүлдэг тэтгэмж эсвэл даатгалын хөтөлбөрт бүрдгүүлэхийг шаардах;
2. Энэ хэсэгт заасан үйлчилгээтэй холбогдох даатгалын төлбөр нэхэмжлэх үед үүсэх даатгалын урьдчилгаа төлбөр, хураамжийг эцэг эхчүүдээс нэхэмжлэх, харин эцэг эхийн төлөх ёстой байсан төлбөр хураамжийг орон нутгийн боловсролын агентлагууд барагдуулж болно;
3. Хэрэв дараах нөхцөл байдал үүсэхээр бол төсвөөс үзүүлдэг халамжийн тэтгэмж юм уу даатгалаар хүүхдэд хамаарах тэтгэмжийг ашиглахыг хориглоно:
 - a. Хүүхдийн тэтгэмж, даатгалд хамрагдах эрхийг насан туршид нь бууруулахаар байгаа юм уу эсвэл бусад даатгалын хамрах хүрээг багасгахаар бол;
 - b. Хүүхэд сургуулиас гадуур байх үед үзүүлэх шаардлагатай төсвийн халамжийн тэтгэмж юм уу даатгалаар төлбөл зохих үйлчилгээг гэр бүл өөрсдөө төлөх нөхцөл үүсгэхээр бол;
 - c. Даатгалын хураамж нэмэгдэх эсвэл тэтгэмж, даатгалыг бүрмөсөн зогсоохоор бол;
 - d. Эрүүл мэндтэй холбоотой нийт зардлуудын улмаас орон сууц болон олон нийтийн хөтөлбөрүүдэд хамрагдах эрхээ алдах эрсдэл үүсэхээр байгаа бол.

ⁱ VDOE- Virginia department of Education: Виржиниа Мужийн Боловсролын Яам. Энэ бичиг баримтад цаашид **VDOE** гэж товлох. Орчуулагч.

ⁱⁱ Due Process- Монгол хэлэнд “эрхзүйн зайлшгүй процесс”, “Процессын Эрх” гэх мэтЯлгавартай орчуулсан бий. Энэ нь эрхзүйн хүрээнд заавал дагаж мөрдөх үйл явц (процесс) гэсэн утгатай. Энэ бичиг баримтад “**Эрхзүйн процесс**” гэж товчлон орчуулав. Орчуулагч.

ⁱⁱⁱ Due Process Hearing - Эрхзүйн хүрээнд заавал дагаж мөрдөх үйл явц (процесс)-г хангуулах эрхийн хүрээнд явуулах сонсгол. Энэ бичиг баримтад “Эрхзүйн Процессын Сонсгол” гэж орчуулав. Орчуулагч.